

**2. МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН (Ж-4.6, Х-3-1.1.)**

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор эдгээр баримт бичигт суурилсан аймгийн 2021 он хүртлэх “Хөгжлийн хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ-ын 2008 оны 08/01 дугаар тогтоолоор баталж, хэрэгжилтийг хангах ажил аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг , нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөв төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байна.

МХЗ-уудыг орон нутагт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх богино хугацааны төслийг НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр тус аймагт хэрэгжүүлж аймгийн МХЗ-уудын тулгамдаж буй асуудал, хэрэгжилтийн талаар анхны тайланг бичиж аймгийн өнөөгийн нөхцөл байдлыг бодитойгоор үнэлж, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, улмаар орон нутгийн удирдлагын цаашдын үйл ажиллагаа, бодлого зорилтын чиглэл, арга зам, хүрэх түвшинг тодорхойллоо.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн 57 зорилтоос 100% хэрэгжсэн 13 заалт, 90% хэрэгжсэн 38 заалт, 70% хэрэгжсэн 6 заалт , дундач биелэлт **90.1** хувьтай байна.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг хавсаргав.

ХАВСРАЛТ

**МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ
ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ**

Стратегийн зорилтууд	Авах арга хэмжээ	Биелэлт	Хувь
4.1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого			
Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, гэр бүлийг бэхжүүлэх, хүний амьжиргааны чадамжийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоог эрс шинэчлэх үндсэн дээр ядуурлыг бууруулж Мянганы хөгжлийн зорилтуудыг биелүүлэх бодлого баримтална.			
Стратегийн зорилт 1. Ядууст чиглэсэн, харьцангуй чинээлэг дунд давхаргыг төлөвшүүлэх эдийн засгийн бодлого	Эдийн засгийн өсөлтийг ядуурлыг стратегийн бичгийг Монгол Улсын Мянганы хөгжлийн	Сумын Засаг дарга нартай хийх бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд сумын хүн ам , ажилгүй иргэдийн тоо , үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломж зэргийг үндэслэн шинээр бий болгох ажлын байрны	70

<p>хэрэгжүүлж, орлогын өсөлтийг хангах замаар ядуурлыг хоёр дахин бууруулна.</p>	<p>зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх зорилтуудтай уялдуулан хоёр жилд нэг удаа шинэчлэн сайжруулж, хэрэгжилтийг нь эрчимжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдуулан ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 3 хувиас ихгүй байлгах ▪ Өрх, хүн ам, амьжиргааны түвшний талаархи үндэсний хэмжээний мэдээллийн сан байгуулна. Ажилгүй, ядуу, нэн ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага туршлага эзэмшүүлэн, ажлын байртай болгох, хөгжлийн зээл, тусламжид хамруулах зэргээр амьжиргааны эх үүсвэртэй болох, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ▪ ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгох 	<p>төлөвлөгөө өгч, ажилгүй иргэдийг мэргэжил олгох түр сургалтанд хамруулах, нийтийг хамарсан ажлын төсөл хэрэгжүүлэх, иргэдийг жижиг зээлийн үйлчилгээнд хамруулж шинэ ажлын байртай болгох арга хэмжээг хамтран авч хэрэгжүүлсний үр дүнд 1409 хүнийг ажилд зуучилж байнгын ажлын байраар хангалаа. Мэргэжил олгох сургалтанд ажилгүй, ядуу, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг жигд хамруулан сургахаас гадна ажил олгогч байгууллагын захиалгаар албан бус салбарт ажиллагсдыг сургах чиглэл баримтлан ажилласны үр дүнд жил эцсийн байдлаар 22 төрлийн мэргэжлээр 605 хүнийг сургаж мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ олголоо. Аж ахуй эрхлэх, төсөл хөтөлбөр боловсруулах сургалтыг 9 удаа зохион байгуулж 200, малчны сургалтыг 4 удаа зохион байгуулж 100 хүнийг тус тус хамрууллаа.</p> <p>Аймаг сумын хэмжээнд нийтийг хамарсан ажлын 54 төсөл шалгаруулан зохион байгуулж 1496 ажилгүй иргэдийн түр ажлын байртай болгож 101.9 сая төгрөгийн цалин хөлс олголоо. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын нэг хэсэг нь хувиараа буюу хоршоо нөхөрлөлийн хэлбэрээр хөдөлмөр эрхлэх иргэнийг дэмжих жижиг зээлийн үйлчилгээ бөгөөд Хас, Монгол шуудан, ХАА-н банкаар дамжуулан иргэн, аж ахуйн нэгжид 496 ажлын байранд 425000,0 мянган төгрөгийн зээл олгож хяналт тавьж ажиллаа. 49 хүнд зээлийн хүүгийн нөхөн төлбөрт 6977,5 мянган төгрөг олголоо.</p> <p>Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг үндэслэн тухайн өрхийн хөдөлмөрийн насны хүн амыг мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах</p>
--	--	--

		<p>үйлчилгээнд хамруулж, мэргэжил олгох, ажлын байртай болгох асуудлыг дэс дараатай авч хэрэгжүүлж, хамрагдсан өрхийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг хийж эхлээд байна. Аймгийн хэмжээнд 560 өрхийн мэдээллийн сан бүрдлээ.</p> <p>Хөдөлмөр эрхлээгүй хүн ам, ажилгүйчүүдтэй ажиллахын зэрэгцээ ажил олгогч нарыг урамшуулан дэмжих, ажилгүйдлээс урьдчилан сэргийлэх мэргэжлийн зөвлөгөө өгөх зэрэг арга хэмжээний үр дүнд 3202 хүнд мэргэжлийн зөвлөгөө өгч, 15 байгууллагын 84 хүний ажлын байрны нөхөн төлбөрт ажил олгогчдод 56897,4 мянган төгрөг зарцууллаа. Аймгийн хэмжээний ядуу өрхийн судалгааг гаргаж 560 өрхийн мэдээллийн сан бүрдүүллээ. Шаардлагатай 384 өрхөд өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд 63,2 хувь буюу 243 өрхийн амьжиргаа дээшиллээ.</p>	
--	--	---	--

4.2. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого

Жендэрийн тэгш байдлыг гэр бүл, эдийн засаг, нийгэм, улс төр, соёл, хүний эрхийн хүрээнд хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

<p>Стратегийн зорилт 1. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үндэсний соёлын дэвшилтэт уламжлал, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололттой хослуулан төлөвшүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг төрийн бодлого, хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж, бие даасан хуультай болох ▪ бүх шатны боловсролын хөтөлбөрийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй болгох ▪ өмчийн болон хөдөлмөрийн харилцаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийг адил, тэгш оролцуулах соёлыг хэвшүүлэх ▪ удирдах, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх 	<p>Удирдах, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2 хоногийн сургалтыг МГБССН, ХХҮХ хамтран зохион байгуулж, 18 сумын нийгмийн ажилтан, Улаангом сумын 17 иргэнийг оролцуулж сургалтын үеэр 1630 ширхэг гарын авлага бэлдэж иргэдэд түгээхээр тараалаа. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсгийг шинэчлэн Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулж, аймгийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Сумдын эхчүүдийн төрөхийн өмнөх амрах байрыг засварлах, тохижуулах ажил тогтмол хийгдэж байна. Шинээр гэрлэгсэд, өсвөр үеийнхэн, залуучуудын дунд жендэр, гэр бүлийн боловсрол олгох сургалтууд</p>	<p>90</p>
--	---	--	------------------

		<p>зохион байгуулах ажил хийгдэж байна.</p> <p>Хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах түр байр ажиллуулах, гэрлэх ёслолыг бүртгэх ордон танхимыг аймаг, сум дүүрэгт бий болгон ажиллуулах асуудал хөрөнгө мөнгөний дутагдлаас хамааран хэрэгжихгүй байна.</p> <p>Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд “Үр хөндөлтөөс сэргийлье”, ДОХ-той тэмцэх өдрөөр ” ДОХ-ын эсрэг Хамтдаа ”, телевизийн ярилцлагыг эх барихын ерөнхий мэргэжилтэн, өсвөр үеийн эмч,нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан болон ТББ-ын төлөөлөлтэй хамтран хийж, “Ажлын байрны стресс” ,”Жендерийн тухай ойлголт” лекцийг 90 гаруй хүнд уншиж,Увсын амьдрал сонинд мэдээлэл бичиж хэвлүүлсэн нь олон нийтэд мэдээлэл хүргэсэн, сонсогч уншигчдын мэдлэгийг нэмсэн ажил байлаа.</p>	
--	--	--	--

4.3. Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого

Гэр бүл бат бэх байх, үр хүүхэд аюулгүй орчинд эрүүл өсөж хөгжих, уламжлалт ёс заншлаа хүндлэх, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, авъяасаа хөгжүүлэх, сурч боловсрох эрмэлзэлтэй, бүтээлч, хариуцлагатай, хувь заяандаа эзэн иргэн болж төлөвших нөхцөлийг бүрдүүлж, хүн амаа өсгөх бодлого баримтална.

<p>Стратегийн зорилт</p> <p>1. Гэр бүлийг хүний аж төрөх таатай орчин болгоход чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлнэ</p>	<ul style="list-style-type: none"> ▪ гэр бүлийг уламжлалт соёл, ёс заншлын өвийг хадгалан хөгжүүлэх орчин болгох ▪ ядууралд орсон болон эмзэг бүлэгт хамрагдаж буй гэр бүлийн онцлогт тохирсон “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г тэдний өөрсдийн оролцоотойгоор боловсруулж, түүнд үндэслэн амьжиргааг дээшлүүлэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлэх ▪ бүтэн өнчин, хаягдмал, гэр бүлээсээ дайжсан, хараа хяналтгүй хүүхдийг гэр бүлд, эсхүл гэр бүлтэй нь дүйцэхүйц 	<p>Аймгийн хэмжээнд 560 өрхийн мэдээллийн сан бүрдүүлж, тэдгээр өрхөөс 380 өрхийг сонгон авч өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, тухайн өрхийн хөдөлмөрийн насны хүн амыг мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамруулж, мэргэжил олгох, ажлын байртай болгох замаар амьжиргааг нь дээшлүүлэх асуудлыг дэс дараатай авч хэрэгжүүлэх ажлыг хийж эхлээд байна.</p>	<p>90</p>
--	--	---	------------------

	<p>халамжийн таатай орчинд өсгөж хүмүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> ▪ “Гэр бүл, хүүхдийн цогц хөгжил” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ▪ өрх бүр угийн бичгээ хөтөлж, удамшлын доголдол, оюун ухааны хомсдолоос хамгаалах бодлого хэрэгжүүлэх 		
<p>Стратегийн зорилт 2. Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хүний эрхэд суурилсан гэр бүл төвтэй төрийн цогц бодлого хэрэгжүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ хүн амын тодорхой бүлгийн онцлог хэрэгцээнд тохирсон урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх, хамгаалах, зуучлах нийгмийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх ▪ өсвөр үе, залуучуудад ардчилсан, эх оронч үзэл, үндэсний уламжлал, хэл соёл, зан заншлыг төлөвшүүлэх ▪ хүн амын бүтцэд гарах өөрчлөлт, наслалтын асуудлыг нийгмийн бодлого, хөтөлбөр, хөгжлийн төлөвлөлтөд тусгах орчныг бүрдүүлэх ▪ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох таатай орчныг бүрдүүлэх 	<p>Өсвөр үе, залуучуудад ардчилсан, эх оронч үзэл, үндэсний уламжлал, хэл соёл, зан заншлыг төлөвшүүлэх зорилгоор Увсын залуучууд хөтөлбөрийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгон олон талт ажлуудыг тусган хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.</p> <p>2030 он хүртэлх хүн амын хэтийн тооцоог 3 хувилбараар боловсруулж, аймгийн хөгжлийн хөтөлбөр бусад холбогдох бодлогын баримт бичгүүдэд хүн амын бүтцэд гарах өөрчлөлт, насжилтыг угтах стратегийг тусгаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан сумдад хүргүүлээ. “Колумбия-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш боломжийн төлөө” 3 сарын аяныг зохион байгуулж, Саадгүй өдөр -1, Саадгүй өдөр-2 , Саадгүй өдөр -3 арга хэмжээний хөтөлбөрт Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдугаар чуулга уулзалт, сумдын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөлүүдийн чадавхижуулах сургалт, спорт биеийн тамирын арга хэмжээг тус тус тусган амжилттай хэрэгжүүлээ.</p> <p>Спорт биеийн тамирын арга хэмжээнд нийт 250 гаруй ХБИ гар бөмбөг, даам, багуудын хооронд олс таталтын төрлөөр өрсөлдлөө.</p>	<p>90</p>

<p>Стратегийн зорилт 3. Эцэг, эх үр хүүхдээ эрүүл, саруул өсгөн бойжуулж, боловсрол хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхийг төрөөс дэмжинэ. Төрөлтийг дэмжих замаар хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, улмаар хүн амаа өсгөх бодлого баримтална.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ эхийн эрүүл мэндийг жирэмслэлтийн эхэн үеэс хамгаалах, ургийн бойжилтыг оношлох, хянах, хүүхдийг нэг нас хүртэлх хугацаанд шаардлагатай тохиолдолд нэмэлт тусгай хоол, хүнсээр үнэ төлбөргүй хангадаг үндэсний жишиг боловсруулан тогтоож хэрэгжүүлэх ▪ амаржсан эхчүүдийн хүүхэд асарсны тэтгэмжийг сарын дундаж цалингаас багагүй байлгаж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцан төлөх ▪ 0-18 насны дөрөв ба түүнээс олон хүүхэдтэй гэр бүлийн эх /эцэг/-д олгох цалингийн, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын урамшууллын тогтолцоог хуульчлан хэрэгжүүлэх ▪ 0-18 насны дөрөв болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийг орон сууцны байраар хөнгөлөлттэй үнээр хангах бодлого хэрэгжүүлэх 	<p>НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөр хэрэгжиж өрх, гэр бүлийг чадваржуулах чиглэлээр өрхийн гишүүдийн эрүүл мэнд, боловсролыг дэмжих, цэвэр орчин бүрдүүлэх олон салбар хамарсан төслүүдийг Тэс, Наранбулаг суманд хэрэгжүүлж бусад сумдад түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна. Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран олон улсын гэр бүлийн өдрөөр үр хүүхдээ эрүүл саруул, эрдэм боловсролтой, хүмүүжилтэй хүн болгон өсгөсөн гэр бүлүүдийг шалгаруулж шагнах ажлыг зохион байгууллаа. Төрөлтийг дэмжих олон талт арга хэмжээнүүд зохион байгуулсны үр дүнд төрөлтийн түвшин өмнөх оноос нэмэгдэж, хүн амын тоо өмнөх оноос 200 гаруй хүнээр нэмэгдлээ. Төрийн албан хаагчдын байр ашиглалтанд орж 20 айл хөнгөлөлттэй үнээр шинэ байранд орлоо.</p>	<p>90</p>
<p>Стратегийн зорилт 4. Хүүхэд эхээс төрсөн цагаасаа зургаан нас хүртэл гэр бүл, эсхүл түүнтэй дүйцэх орчинд өсөж торних, зөв хүмүүжил, ёс суртахуунтай болох, сургуулийн өмнөх боловсрол олгоход төрөөс онцгой анхаарна.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ хүүхдийг хөхөөр хооллох, зургаан нас хүртэл нь эрүүл мэндийн тусгай хяналтанд байлгах нөхцөл бүрдүүлэх ▪ амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдийг зургаан нас хүртэл нь насны онцлогт тохирсон эрүүл хоол хүнсээр хөнгөлөлттэй үнээр хангах ▪ хүүхдийг бие 	<p>Хүүхдийг төрсөн цагаас эхлэн таатай орчинд өсгөх, хөхөөр хооллох, эрүүл хоол хүнсээр хангах, хүүхдийг бие бялдар, эрүүл мэнд, оюун ухаан, сэтгэцийн зөв хөгжилтэй, үндэсний хэл, сэтгэлгээтэй болгон хүмүүжүүлэхэд эцэг, эх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын байгууллагын үүргийг өндөржүүлэх зорилгоор Нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөр, НҮЭМ хөтөлбөр, бусад хөтөлбөр, төслийн хүрээнд холбогдох</p>	<p>90</p>

	<p>бялдар, эрүүл мэнд, оюун ухаан, сэтгэцийн зөв хөгжилтэй, үндэсний хэл, сэтгэлгээтэй болгон хүмүүжүүлэхэд эцэг, эх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын байгууллагын үүргийг өндөржүүлэх</p>	<p>ажилтнуудад чиглэл чиглэлийн сургалтуудыг зохион байгуулж байна. Нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөрийн хүрээнд 100 сургагч багшийн сургалтыг эх хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл, бага насны хүүхдийн хөгжил, цэвэр орчин сэдвээр хийж, хүүхдийн оролцоо сэдвээр 45, цэвэр орчин эрүүл мэнд сэдвээр 30 үе тэнгийн сургагч багшийн сургалтыг зохион байгуулаа.</p>	
--	---	---	--

4.4. Боловсролын хөгжлийн бодлого

Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ. “Боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 2008 оноос ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэн 2015 он гэхэд хөвгүүд, охидыг бага боловсролд бүрэн хамруулж, хүйсийн тэгш бус байдлыг арилгана. Ур чадвар сайтай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, дээд боловсрол олгох тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх бодлого баримтална. 2021 он гэхэд олон улсын жишигт нийцсэн боловсролын тогтолцоонд шилжинэ. Орон даяар оюун ухааныг эрхэмлэн дээдэлж амьдрах сэтгэл зүйн орчин бүрдүүлж, боловсролын бүх шатны сургалтыг 21 дүгээр зууны оюунжсан шинэ хандлагад зохицуулан өөрчилнө.

<p>Стратегийн зорилт 1. Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ</p>	<ul style="list-style-type: none"> ▪ бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх ▪ бүх шатны боловсролын байгууллагын суралцагчид болон багшийн хүйсийн харьцааг тэнцвэртэй болгох ▪ боловсрол нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх ▪ хөдөөгийн малчин өрхийн 0-6 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг нүүдлийн аж байдалд нь тохируулан зохион байгуулах ▪ 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах ▪ хөвгүүдийн боловсролын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх 	<p>Тариалан, Улаангом сумын 1-р цэцэрлэгт өргөтгөл барьж ашиглалтанд орж, ор хоног 125 – аар , Цагаанхайрхан, Наранбулаг, Түргэн сумуудад тус бүр 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг баригдаж 2009-2010 оны хичээлийн жилийн эхнээс ашиглалтанд орж байна. Цэцэрлэгийн хүчин чадал 425 ор хоногоор нэмэгдэж байна. Цэцэрлэгийн орны тоо 2405 боллоо Хүүхдийн хоолны зардал 2009.4-р сарын 1 ээс эхлэн 658 -1100 төгрөг болж өссөн. Увс аймгийн хэмжээнд төрийн өмчийн 25 цэцэрлэгийн 2864 хүүхдэд хувьсах зардал олгосон.</p> <ul style="list-style-type: none"> ▪ НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Завхан, Зүүнхангай, Тэс, Наранбулаг, Тариалан, Цагаанхайрхан, Хяргас сумуудын багуудад 17 нүүдлийн гэр цэцэрлэг, Дэлхийн банкны санхүүжилтээр “Үр дүнд түргэн хүрэх санаачилга” төслөөр Зүүнговь, Тэс, Ховд, Сагил сумуудад 8 гэр цэцэрлэг, орон нутгийн нөөцөөр 10 гэр цэцэрлэг 	<p>90</p>
--	--	---	------------------

	<ul style="list-style-type: none"> ▪ ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тохилог орчинг бүрдүүлж, дотуур байранд суух хүүхдийн тоог 2.1 дахин нэмэгдүүлэх ▪ ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлэх ▪ 2010 он гэхэд хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшинг 99.0 хувьд хүргэх 	<p>бүгд 36 нүүдлийн гэр цэцэрлэг ажиллаж байна. Нүүдлийн гэр цэцэрлэгийн сургалтанд 1311 хүүхэд хамрагдаж байна. СӨБ-д 4960 хүүхэд суралцаж, хамран сургалт 78.4 хувьтай байна.Одоогоор хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулагдаагүй. Сургуулийн боловсролын талаар төрөөс баримталж байгаа бодлогын үр дүнд 2008 онд цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг 370,5-459,3 болгож нэмэгдүүлсэн. Мөн Сургуулийн өмнөх боловсролын тухай бие даасан хууль гарч төрөөс цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 100 хувь гаргаж үндсэн үйл ажиллагааны орлогыг 2009 оны 1-р сараас эхлэн чөлөөлсөн.</p> <ul style="list-style-type: none"> • НҮБ-ийн Хүүхдийн сангийн *Нийгмийн цогц суурь үйлчилгээ*,Үр дүнд түргэн хүрэх саначилгын түншлэл* хөтөлбөрт хамрагдсан Тэс, Наранбулаг, Зүүнговь, Ховд, Сагил сумын цэцэрлэгүүдэд тоглоом наадгай олгогдсон ба НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 14 цэцэрлэгт 40,0 сая төгрөгийн хувилбарт сургалтын хэрэглэгдэхүүн, мөн Тэс, Наранбулаг суманд 16.7 сая төгрөгийн өртөг бүхий нарны зайн үүсгүүр, тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл олгогдсон. Улсын төсөв, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Улаангом сумын 1-р цэцэрлэгт 717,5 сая төгрөгийн үнэ бүхий гал тогооны тоног төхөөрөмж ирсэн.Улсын төсөв, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Тариалан, Түргэн сумын цэцэрлэгт 22,396 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Тогтвортой амьжиргаа төслийн хүрээнд 56,03 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хатуу зөөлөн эдлэлийг шинэчилэн сайжруулж хүүхдийн хөгжих ая таатай орчинг бүрдүүлсэн байна. • Бага боловсролын нас/6-11/- 	
--	---	---	--

		<p>ны 10789 хүүхдээс 10190 хүүхэд сургуульд хамрагдаж байгаа ба хамрагдалтын хувь 94.4 байна. 2008-2009 оны хичээлийн жилд сургуульд иргэдэд дүйцсэн хөтөлбөр болон дүйцсэн боловсрол нөхөн олгох зорилгоор нийт 1089 иргэдийг хамруулан сургаж байгаа ба үүнээс бага боловсрол олгох сургалтанд 464, суурь боловсролд 434, бүрэн дунд боловсролд 191 хүнийг суралцуулж, 254 хүнд бага боловсрол, 199 хүнд суурь боловсрол, 150 хүнд бүрэн дунд боловсрол эзэмшүүлж, дараа шатны сургалтанд хамруулах нөхцөл бололцоог хангав. 2009 – 2010 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрөөр бага бага боловсролд 452, суурь боловсролд 444, бүрэн дунд боловсролд 250, бүгд 1146 суралцагчийн харуулан сургаж эхлээд байна. Үүнээс хичээлийн жилийн төгсгөлд 250 хүнд бага боловсрол, 235 хүнд суурь боловсрол, 162 хүнд бүрэн дунд боловсрол олгохоор тухайн шатных нь төгсөх ангид суралцуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> • “ЕБС-ийн” Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж ,сургуулиудын цайны газрыг тоног төхөөрөмжөөр хангах зорилтын хүрээнд Цагаанхайрхан сумын сургуулийн гал тогоонд БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 1сая 900 төгрөгийн шарах шүүгээ, 350мянган төгрөгийн хөлдөөгч нийлүүлсэн байна. Мөн тогтвортой амьжиргаа төслөөр Зүүнхангай сумын сургуульд 15 сая төгрөгийн гал тогооны цахилгаан тоног төхөөрөмж , Тариалан сумын цэцэрлэгт 2,7сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийг бэлтгэн нийлүүлсэн. .Зарим сургуулиуд санаачлага гарган нутгийн зөвлөл ,УИХ-ын гишүүд ,төгсөгчдийн хандив тусламжаар дотуур байрны гал тогоог тохижуулсан байна. 	
--	--	--	--

		<p>Үдийн цай хөтөлбөрт 2009 оны 1-6сард Увс аймгийн ерөнхий боловсролын 27 сургуулийн 1-5 ангийн 10339 хүүхэд хамрагдаж 323,129,7 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн. 2009-2010 оны хичээлийн жилд үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байгаа сурагчдын тоо 10683 болж өмнөх оныхоос 344 хүүхдээр өссөн тоон үзүүлэлт гарч байна. Энэ онд “Үдийн цай “ хөтөлбөрийн санхүүжилтэнд нийт 638,478,3 мянган төгрөг зарцуулсан.</p> <p>Энэ хичээлийн жилд Баруунтуруун сумын ахлах сургуульд 50 хүүхдийн, Өлгий сумын ахлах сургуульд 80 хүүхдийн, Зүүнговь сумын ахлах сургуульд 100 хүүхдийн ор бүхий дотуур байр шинээр баригдаж, Бөхмөрөн сумын дунд сургууль 60 хүүхдийн дотуур байрыг засварлаж ашиглалтанд оруулснаар дотуур байрны багтаамж аймгийн хэмжээнд нийт 290 ороор нэмэгдлээ.</p> <ul style="list-style-type: none">• Бичигтэн болох “НҮБ-ын 10 жил”-ийн ажлын хүрээнд бичиг үсгийн боловсрол олгох талаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас Боловсрол, соёлын газрын даргатай байгуулсан гэрээний дагуу сумын Засаг дарга, сургуулийн захирал, албан бус боловсролын багш нартай гэрээ байгуулан зуны сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Бичиг үсгийн сургалтыг зохион байгуулахын тулд шинээр хэвлэгдэн гарсан “Билгийн нүд”, “Амьдралын их сургууль” сурах бичиг, гарын авлагыг төвөөс татан авч сургалтанд ашиглуулахаар гэгээрэл төвүүдэд хүргээд байна.• Бичиг үсгийн сургалтанд ашиглах гарын авлага, ном, CD, кассетийг бүх сумын албан бус боловсролын багш нарт хүргүүлэн сургалтандаа ашиглаж эхлээд байна.	
--	--	--	--

		<p>- Бичиг үсэг үл мэдэгч нийт 480 гаруй хүн байгаа ба үүнээс 350 хүнийг сургалтанд хамруулж, 200 хүнийг бичигтэн болгож дараа шатны сургаж байна.2009 оны эцэст 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалт 99.1% болж бичиг үсэгт тайлагдаагүй залуучууд 0.09%-ийг эзэлж байна.</p>	
<p>Стратегийн зорилт 2. Боловсролын бүх түвшний стандарт, сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан боловсролын стандартын шалгууруудыг нарийвчлан тогтоох ▪ бүх түвшний боловсролын агуулгыг үндэсний ухамсар, мэдрэмж, түүх, соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх, өөрийн соёлыг дээдлэхийн хамт бусдын соёлд хүндэтгэлтэй хандах, оюун ухааныг эрхэмлэх, бүтээлчээр сэтгэх чадвар, мэдлэг, хүмүүжил олгоход чиглүүлж, суралцагчдын сонгох боломжийг өргөжүүлэх ▪ сургуулиудыг олон улсын боловсролын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй болгох ▪ боловсролын шинэчлэл-өөрчлөлтийг эхлэн туршиж зүгшрүүлдэг “Туршилтын бааз сургуулиудын лаборатор бүтэц”-ийг буй болгоно. Үүнд: Улаанбаатар хотод 10 хүртэл, аймаг бүрт 2 хүртэл тооны сургуулийг сонгох буюу шинээр байгуулах замаар хамруулж, боловсролын шинэчлэлийн 	<p>Сургуулийн гэгээрэл төвүүдийг түшиглэн эрүүл мэнд, эрх зүй, экологи, эдийн засгийн зэрэг сургалтуудыг тусгай график, хөтөлбөрийн дагуу иргэдийн дунд явуулж, хөдөөгийн иргэдэд гарын авлага, материалыг хүргүүлэн судлуулж байна. 2009 онд 253 удаагийн сургалт зохион байгуулж 36400 хүнийг сургалтанд хамруулав. Мэдээллийн технологи ашиглан англи хэлний сургалт явуулах “Дайнид” хөтөлбөрийн хүрээнд 2008.03-р сард тус бүр орчин үеийн 21 компьютер бүхий англи хэлний иж бүрэн 4 лаборатори БХХ-ийн хүрээнд нийлүүлэгдсэн. 2008 оны 10-р сараас эхлэн “Эрдэм-Оргил”цогцолбор , “Шинэ-Ирээдүй” цогцолбор, “Чандмань-Эрдэм” ахлах сургууль, Баруунтуруун сумын ахлах сургуулиудад англи хэл сурах сонирхолтой тус бүр 100 сурагчтай 20 ангийн нийт 400 гаруй сурагч мэдээллийн технологи, интернет ашиглан англи хэлний онлайн сургалтанд 2009 оны 03-р сарын 31 хүртэл хамрагдсан. Энэ хугацаанд 2008.12-р сард хөтөлбөр хэрэгжиж байгаа 192 сургуулийн оюутан сурагчдын дунд улс орон даяар онлайн олимпиад зохион байгуулагдсан бөгөөд тус олимдиадад 3000 сурагчдаас “Шинэ-Ирээдүй” цогцолбор сургуулийн сурагч А.Тунгалаг 2-р байр эзэлсэн.</p> <p>2009-2010 оны хичээлийн жилийн 1-р улирлын сургалтанд Баруунтуруун сумын Ахлах</p>	<p>100</p>

	<p>санаачилгыг дэмжих</p> <ul style="list-style-type: none"> ▪ бүх нийтийн монгол хэл, бичгийн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, бүх шатны сургуульд эх хэлээ төгс эзэмшиж ашиглах, бичих, илтгэх ур чадварыг хөгжүүлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх ▪ 2015 онд багтаан англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох ▪ 2015 он хүртэлх хугацаанд бүх нийтийн англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, дээд боловсрол эзэмшигчид ажил, мэргэжлээрээ шаардлагатай мэдээллийг англи хэлээр ашиглах чадвартай болгох. 2021 он гэхэд төрийн захиргааны төв байгууллагын ажилтнууд албан ажлаа англи хэлээр явуулах чадамжтай болох ▪ боловсролын хөгжлийн бодлогод дүн шинжилгээ хийх, шинэчлэлийн онол-арга зүйн үндсийг боловсруулах судалгааны чадавхийг бэхжүүлж, төрөөс санхүүжүүлэх 	<p>сургуулийн 108, “Эрдэм Оргил” цогцолбор сургуулийн 71 нийт 179 сурагч үргэлжилүүлэн суралцаж байна.</p>	
<p>Стратегийн зорилт 3. Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ багш, удирдах ажилтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчлэн сайжруулж, энэ чиглэлд мэргэжлийн төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх ▪ багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны ур чадварыг хөгжүүлж, ажлын чанар, 	<p>Засгийн газрын 2008 оны 316-р тогтоолоор батлагдан гарсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийг бүх сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлэн хөтөлбөрийн дагуу дэд хөтөлбөр боловсруулан, мөн багш өөрийн мэдлэг боловсролоо ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж</p>	<p>100</p>

	<p>хөдөлмөрийн үр бүтээлийг үнэлэх шалгууруудыг зөв тогтоож, цалин хөлс нэмэгдүүлэх, урамшуулал олгох зэргээр нийгмийн хамгааллыг сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> ▪ газар нутгийн алслагдалт, цаг уурын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох ▪ дотооддоо мэргэжил дээшлүүлэх нийт зардлыг 2004 онтой харьцуулан 2007 оноос эхлэн ойролцоогоор 6 дахин нэмэгдүүлж, цаашид жил бүр 10 хувиас доошгүй өсгөх 	<p>ажиллаад байна. Мөн БСШУ-ны сайдын 2008 оны 114-р тушаалаар батлагдан гарсан “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулах журмын дагуу сургууль, цэцэрлэгүүд шаардлагад нийцүүлэн тохижуулж, багш нар ажлын байран дээрээ мэргэжил боловсролоо дээшлүүлэх чиглэлээр санаачлага гарган ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгүүдэд очиж ажиллах үедээ багш нарын хичээлд суух, хамтран хичээл бэлтгэх, заах ажлыг зохион байгуулахаас гадна нийт багш нарт “Ээлжит хичээлийн бэлтгэлийг сайжруулж, сургалтын чанарыг дээшлүүлэх”, “Багшийн ажлын үнэлгээ” зэрэг сэдвээр сургалт явуулсан. 2009 онд боловсролын хуулийн 43.1.4 дүгээр заалтын дагуу сургуулийн 19 багшид 93224.1 мянган төгрөг, цэцэрлэгийн 7 багш ажилтанд 47656.0 мянган төгрөгийн тэтгэмж, мөн хуулийн 43.1.7 дахь заалтын дагуу сургуулийн 47 багшид 64735.9 мянган төгрөг, цэцэрлэгийн 1 багшид 1377.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. 2008 оны 54 тогтоолын дагуу 2009 оны 1-р улирлын үр дүнгийн урамшуулал ерөнхий боловсролын сургуулийн 1693 багш ажилтанд 472 сая 723 мянган төгрөг, цэцэрлэгийн 413 багш ажилтанд 128 сая 98 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон байна.</p>	
--	---	---	--

4.5. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого

Монгол Улсын хүний эрүүл мэндийн хөгжлийн бодлого нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулж, хүн амын цэвэр өсөлтийг дэмжиж, дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн оновчтой болгоно. “Эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. 2015 он гэхэд Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангасан байна.

<p>Стратегийн зорилт 1. Сум, өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх,</p>	<p>Эх, нялхсыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох</p>	<p>Өнгөрсөн мөн оны түвшинтэй харьцуулахад эхийн эндэгдэлгүй ажилласан боловч нялхсын эндэгдэл /амьд төрсөн 1000 хүүхдэд/ 8.5, 0-5 хүртэлх насны</p>	<p>90</p>
--	---	--	-----------

<p>шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалт хийх, шүдний өвчин эмчлэх, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэгээс сэргийлэх, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлнэ.</p>		<p>хүүхдийн эндэгдлийн түвшин /амьд төрсөн 1000 хүүхдэд/ 10.0 пунктаар тус тус нэмэгдсэн.</p> <p>Тав хүртэлх насны хүүхдийн гэрийн эндэгдлийн эзлэх хувь, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээний хувь харьцангуй доогуур үзүүлэлттэй байна.</p> <p>2009 онд нийт 2253 эх төрж 2386 хүүхэд эсэн мэнд эх барьж эцэг эхэд нь хүлээлгэн өгсөн байна. Хүүхдийн эндэгдэл улсын дундаж түвшингээс өндөр байгааг анхааран оны эхнээс Эх, хүүхдийн эрүүл мэндэд төр, төрийн бус байгууллага иргэдийн оролцоо сэдэвт сургалтаас гарсан уриалгыг сайшаан Засаг даргын албан тоотыг хавсарган бүх сумдад хүргүүллээ.</p> <p>Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаа.</p> <p>1. Эх хүүхдийн өвчлөл эндэгдлийг тууштай бууруулж эмч эмнэлгийн ажилтны мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлж ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх хөтөлбөрийн хүрээнд суманд сүүлийн 5 жилд эндсэн хүүхдийн эндэгдлийн шалтгаанд 22 эмчээр судалгаа хийлгэж илтгэл тавиулан эндэгдлийг бууруулах зөвлөмжийг нэгжид хүргүүлсэн.</p> <p>Уг зөвлөмжинд нярайн эндэгдлийн шалтгаанд жирэмсний хүнд хөнгөн хордлого 30.4 хувь, төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулрал 19.4 хувь, ихэсийн дутмагшил 12 хувь, ураг орчмын ус эрт гарах 8.5 хувь, өгзөг төрүүлэлт /ургийн толгойн саатал/- 4.9 хувь, хугацаанаас өмнөх төрөлт 3.7 хувь, давтан кесаров 3.7 хувь, ихэс ховхрох 3.7 хувь, эклампси 2.4 хувь, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд нярайн эндэгдэлд золгүй тохиолдол, амьсгалын замын халдвар түүний хүндрэл,, гэртээ</p>
---	--	--

		<p>онош тодорхойгүй, суулгалт өвчнөөр эндсэнээс гадна нийт хүүхдийн 46.1 хувь нь суурь эмгэгтэй байсан нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа сум, өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй, эцэг эхийн асаргаа сувилгаа хүүхдэдээ тавих анхаарал дутмаг байгаатай холбоотой гэсэн дүгнэлтийг тусган хүүхдийн эндэгдэл бууруулан ажиллах чиглэл, арга зүйг дурдаж үйл ажиллагаандаа хэргэжүүлэн ажиллахыг зөвлөсөн болно.</p> <p>2. Хүүхдэд зонхилон тохиолдох зарим эмгэгийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, орчин үеийн хандлага” сургалтыг аймгийн Засаг Дарга , ЗДТГ-ын НХХ , ЭМГ, ЭНЭШТ-ийн сургалт хамтын ажиллагааны албатай хамтын ажиллагаа санхүүгийн дэмжлэгтэйгээр явуулан хүүхдийн чиглэлээр ажиллаж байгаа их эмч нарт ажлын байрны сургалт явуулан 254 хүүхдийг үзэж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>3. Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын 7 хүүхдийн их эмчийг туршлага судлах ажлын байрны, хүүхдийн эмчийн баримжаа олгох, 4 сувилагчийг хүүхдийн дадлагатай ажлын байрны сургалтанд хамруулах</p> <p>4. Амь тэнссэн байдалд хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, Эрэмбэлэн ангилах яаралтай тусламж”-ийн 3-5 хоногийн 2 удаагийн сургалтыг 14 сумын их эмч, нэгдсэн эмнэлэг, өрх багийн эмч, хүүхдийн сувилагч нарт</p> <p>Хүүхдийн өвчний цогц менежмент эмнэлзүйн сургалтыг 11 удаа өрх сумын их, бага эмч, багийн эмч нарын хүрээнд</p> <p>5. Эцэг эхийн тусламж хайх мэдлэг олгох сургагч багш бэлтгэх сургалтыг эх баригч бага эмч, сувилагч бага эмч , НЭМА , эрүүл</p>	
--	--	---	--

		<p>мэндийн туслагч, эцэг эхчүүдэд сургалт явуулж Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг сум, өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, тасралтгүй байдлыг холбогдох эмч мэргэжилтэн нартай хамтран дүгнүүлж ажиллаж байна.</p> <p>6. Жирэмслэлт, төрөх тойрны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор ЭНЭШТ-өөс сургагч багшийг урьж төрөх эмэгтэйчүүдийн эмч нарт ажлын байранд нь ЭХО-ийн дагалдан сургалт хийлээ.</p> <p>ЭМС-ын 2008 оны 10 сарын 02-ны өдрийн 220 тоот тушаалын дагуу 2009 онд 6 сарын хугацаатай гэрээ байгуулан Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг, Бөхмөрөн, Тэс, Тариалан, Ховд сумдад УЭНЭШТ-ийн хүүхдийн дотрын клиникийн амьсгалын эрхтний эмгэг судлалын тасгийн их эмч О. Солонго ажиллуулан ажлын байрны давтан сургалтыг явуулж байсан нь эмч нарын тасралтгүй сургалтанд ач холбогдолоо өгсөн үйл ажиллгаа боллоо</p>	
	<p>Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэтэй тэмцэх чадвартай болгох</p>	<p>Тус аймагт 2009 онд нийт 907 халдварт өвчин бүртгэгдэж өмнөх оноос 5 тохиолдлоор буурч салхинцэцэг, гахайн хавдар, сүрьеэ, хамуу, хүйтэн өвчнүүд нэмэгдэж халдварт шар 66 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>БЗДХ нийт-135 илэрч (тэмбүү 28, заг хүйтэн 52, трихомониаз 26, мөөгөнцөр 20, үү ургацаг 6) хяналтанд орж хавьтлыг судлан илрүүлж эмчилгээнд хамрууллаа.</p> <p>ХДХВ/ДОХ/БЗДХ-н талаархи ойлголт түүнээс урьдчилан сэргийлэх, халдвар дамжих замыг таслан зогсооход хувь хүний үүрэг, бэлгэвчийн хэрэглээ, бэлгэвч хэрэглэх арга” сэдэвт сургалтанд сайн дурын идэвхтэн, өсвөр үеийн</p>	

		<p>зөвлөгч, сумдын эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүн, үе тэнгийн сургагч /7-11 анги/ ЕБС-ийн ахлах ангийн дарга нийт 130 хүнийг сургалтанд хамрууллаа.</p> <p>БЗДХ –ыг хам шинжээр нь оношлох, эмчлэх сургалтанд аймгийн төвийн болон сумдын эх баригч их, бага эмч, өрхийн эмч, сувилагч, лаборант багийн бага эмч нарыг Серологи шинжилгээ хийх арга барил эзэмших дадлагатай сургалтанд хамрууллаа. Аймгийн хэмжээнд Дархлаажуулалтыг товллоор зааврын дагуу хийж хамрагдалт 99.8 хувьтай байна.</p>	
	<p>Малчдад нүүдлийн өрхийн эмнэлгээр үйлчлэх тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>ЭМГ аймгийн нэгдсэн эмнэлгээс хамтран нүүдлийн Нээлттэй хаалга, олон улсын сувилагчийн өдөр, хөдөөгийн баг-62 хөтөлбөрийн хүрээнд төлбөрийн чадваргүй амьжиргааны түвшинээс доогуур, бүртгэлгүй, ЭМД-гүй иргэд, отроор яваа малчдад төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хөдөөгийн 62 багийн 37793 иргэдэд эрүүл мэндийн үзлэг, мэдээлэл сургалт сурталчилгаа, соел урлаг, ахуйн үйлчилгээний явуулын багийн үйлчилгээг үзүүлсэн.</p>	
	<p>Хорт хавдарыг эрт оношилох, эмчлэх боломжоор аймаг, дүүргийн эмнэлгийг хангах</p>	<p>Аймгийн нэгдсэн эмнэлэг хавдрын нэг их эмчийн орон тоотойгоор ажиллаж бусад сумуудад нарийн мэргэжлийн эмчийн тусламж үзүүлж зөвөлгөө өгч байна. Орчин үеийн эмчилгээ оношлогооны тоног төхөөрөмж хангалтгүй байна.</p>	
	<p>Дэлхийн тухайн цаг үеийн стандартад нийцүүлэн эрүүл мэндийн байгууллагын шатлал бүрийн үйлчилгээний арга технологи, холбогдох тоног төхөөрөмжийг байнга шинэчлэх, засвар үйлчилгээг хангах тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар сум, аймгийн нэгдсэн эмнэлэгт зарим нэг тоног төхөөрөмжөөр хангагдаж байгаач засвар үйлчилгээ сургалт хангалтгүй байна.</p>	

	Эрүүл мэндийн байгууллагыг үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйл ажиллагааны зарчимтай болгох	Цаг товолсон амбулаторийн үйлчилгээ, нэг цэгийн үйлчилгээ, иргэдэд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлэн үйлчлүүлэгчдэд чиглэсэн үйлчлэгчийн үйл ажиллагаа сургалтыг тогтмол явуулж төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.	
	Хүний нөөц, мэргэжлийн ур чадварын сургалтыг олон улсын жишигт хүргэх	Хүний нөөцийг 5-10 жилээр төлөвлөн мэргэжил олгох, дээшлүүлэх, ажлын байрны сургалтанд эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнүүдийг хамруулан ажиллаж байна.	
	Эмч мэргэжилтнүүдийн цалин, шагнал, урамшуулал, нэмэгдлүүдийн боловсронгуй тогтолцоог хэрэгжүүлэх	Хүний нөөцийн судалгааг нэгж бүрээр тусгай асуумжийн дагуу бүртгэл хийж ЭМЯаманд хүргүүлэн Сум. сум дундын эмнэлэгт 5-аас дээш жил ажилласан 8 эмч мэргэжилтнүүдэд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний 9867.6 мянган төгрөгийн мөнгөн тусламжийг олголоо.	
Стратегийн зорилт 2. Аймаг, дүүргийн болон улсын клиникийн нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны чадамжийг хөгжүүлнэ.	Хорт хавдарыг эрт оношилох, эмчлэх боломжоор аймаг, дүүргийн эмнэлгийг хангах	Аймгийн нэгдсэн эмнэлэг хавдрын нэг их эмчийн орон тоотойгоор ажиллаж бусад сумуудад нарийн мэргэжлийн эмчийн тусламж үзүүлж зөвөлгөө өгч байна. Орчин үеийн эмчилгээ оношлогооны тоног төхөөрөмж хангалтгүй байна.	90
	Дэлхийн тухайн цаг үеийн стандартад нийцүүлэн эрүүл мэндийн байгууллагын шатлал бүрийн үйлчилгээний арга технологи, холбогдох тоног төхөөрөмжийг байнга шинэчлэх, засвар үйлчилгээг хангах тогтолцоог бүрдүүлэх	ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар сум, аймгийн нэгдсэн эмнэлэгт зарим нэг тоног төхөөрөмжөөр хангагдаж байгаач засвар үйлчилгээ сургалт хангалтгүй байна.	
Стратегийн зорилт 3. Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн өндөр	Эрүүл мэндийн байгууллагыг үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйл ажиллагааны зарчимтай болгох	Цаг товолсон амбулаторийн үйлчилгээ, нэг цэгийн үйлчилгээ, иргэдэд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлэн үйлчлүүлэгчдэд чиглэсэн үйлчлэгчийн үйл	90

<p>мэдлэг, ур чадвартай боловсон хүчнээр хангана</p>		ажиллагаа сургалтыг тогтмол явуулж төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.		
	Хүний нөөц, мэргэжлийн ур чадварын сургалтыг олон улсын жишигт хүргэх	Хүний нөөцийг 5-10 жилээр төлөвлөн мэргэжил олгох, дээшлүүлэх, ажлын байрны сургалтанд эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнүүдийг хамруулан ажиллаж байна.		
	Эмч мэргэжилтнүүдийн цалин, шагнал, урамшуулал, нэмэгдлүүдийн боловсронгуй тогтолцоог хэрэгжүүлэх	Хүний нөөцийн судалгааг нэгж бүрээр тусгай асуумжийн дагуу бүртгэл хийж ЭМЯаманд хүргүүлэн Сум. сум дундын эмнэлэгт 5-аас дээш жил ажилласан 8 эмч мэргэжилтнүүдэд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний 9867.6 мянган төгрөгийн мөнгөн тусламжийг олголоо.		
<p>Стратегийн зорилт 4. Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг ахиулна. Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлнэ.</p>	Хүн амд амьдралын зөв зохистой хэвшил, бие бялдраа чийрэгжүүлэх орчин бүрдүүлэх	Эрүүл мэнд, биеийн тамир спортод холбогдолтой Засгийн газрын тогтоолууд, эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгүүдийг Засаг даргын захирамжаар байгуулан улирал, хагас, бүтэн жилээр тайланг батлагдсан загвар заалтын дагуу нэгтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тогтмол мэдээ, мэдээллийг өгч байна.	90	
	Хүн амын дунд эрүүл аж төрөх, уур амьсгалын дарамт, удамшлын аливаа доголдлоос эрүүл мэндээ хамгаалахад чиглэсэн сургалт, сурталчилгааг өргөжүүлэх	ЭМГ-ын нийгмийн эрүүл мэндийн алба, Мэдээлэл сургалт, сурталчилгаа хариуцсан кабинет хөтөлбөрүүдийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт үнэлгээний төлөвлөгөө гарган ажиллаж дотоодын сургалт 18, бусад байгууллагуудтай хамтран 3 удаа сургалт зохион байгуулж, хяналт үнэлгээний талаар 6 удаа тайлангийн хурал хийсэн байна. НЭМ-ийн хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт 96.1 хувьтай байна. Орон нутгийн САМА ТВ-ийн “Эрүүл мэндийн цаг” нэвтрүүлгийг 7 хоног бүрийн лхагва гаригт нийт 8 удаа хамтран олон нийтэд хүргэлээ.		
	Нөхөн сэргээх, асаргаа,	Аймгийн нэгдсэн эмнэлэгт нөхөн		

	сувилгааны төрлүүдийг хөгжүүлэх	сэргээх физик эмчилгээний кабинет ажиллуулж, сувилахуйн албаны хүн материаллын нөөцийг нэмэгдүүллээ.	
	Уламжлалт анагаах ухааны шилдэг аргыг эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэх	Уламжлалт эмчилгээний 8 ортой тасаг нээн их эмч, бариа засалч эмчийн тоог нэмэгдүүлэн ажиллаж байна.	
	Эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх	Хувийн хэвшлийн эмнэлэг 3, үүдэн эмнэлэг 8, ЭХНБ 4, эмийн сан 4, лаборатори 2 –т тусгай зөвшөөрөл өгч үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.	
	Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх	Гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалт сургалтанд мэргэжилтнүүдийг сургаж төлвөлгөө боловсруулж байна.	
	Олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах замаар хувь хүн, хамт олон эрүүл мэндээ хамгаалах санал, санаачилгыг дэмжин өрнүүлэх	Байгууллага, хувь хүмүүсийн биеийн тамираар хичээллэх, тэмцээнд оролцох үйл ажиллагааг дэмжиж Засаг даргын нөөцөөс 2 сая гаруй төгрөг гаргаж улсын чанартай тэмцээнд иргэд, тамирчдыг оролцуулсан.	
	Сум, дүүрэг, хот суурин газар болон гэр бүл, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх	Эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэх Засаг даргын захирамж гарган жил бүр материалаа ирүүлсэн байгууллагыг урамшуулах тогтолцоотой болсон.	
	Хүн амыг баталгаат ундны усаар хангах, эрүүл ахуйг сайжруулах, химийн болон бусад үйлдвэр, ахуйн хог хаягдлын менежментийг багтаасан амьдралын эрүүл орчин бий болгох замаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх	Ундны усны шинжилгээг тогтмол хийж худаг, худаг, булаг шанд, рашаанд ариун цэврийн бүс тогтоон ажиллаж байна.	

4.6. Соёл, урлагийн хөгжлийн бодлого

Монголын соёл иргэншлийн дэвшилтэт ололт, үнэт зүйлсийг уламжлал, шинэчлэлийн ухаалаг зөв харьцаанд хадгалан хамгаалах, бататган хөгжүүлэх замаар үндэснийхээ соёлын дэлхийн соёлд эзлэх байр суурийг бэхжүүлэх, соёл, урлагийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, оюуны өмчийг хамгаалах бодлого баримтална.

Стратегийн зорилт	■ соёлын удирдлага, зохион байгуулалт,	Увс аймгийн соёл, урлагийн байгууллагын удирдлага зохион	90
1. Үндэсний соёлыг			

<p>эрчимтэй хөгжүүлэх эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг бүрдүүлнэ.</p>	<p>санхүүжилт зах зээлийн эдийн засгийн горимд шилжих үйл явцыг түргэтгэж, салбарын бүх шатанд мэргэжлийн ба удирдлагын ур чадварыг дээшлүүлэх</p> <ul style="list-style-type: none"> ▪ үндэсний болон олон улсын хэмжээнд томоохон ач холбогдолтой бүтээл, туурвил, арга хэмжээг хөгжлийн сангуудаас тодорхой хувиар санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх 	<p>байгуулалтыг МУ-ын Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу соёлын байгууллагын дарга захирлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн аймгийн Засаг дарга томилоно гэсэн хуулийн заалтын хүрээнд зохион байгуулалтыг хийсэн.</p> <p>Соёлын салбарын удирдлага, зохион байгуулалт нь Төрийн бодлого, хууль тогтоомж, Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаал, соёл, урлагийн хөтөлбөр зэргээр зохицуулагдаж холбогдох журам дүрмийн дагуу бүтэц, орон тоогоо батлан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Соёлын байгууллагууд 2009 онд урьд онд хийж гүйцэтгэсэн ажлын биелэлт, үр дүн, ололт дутагдлаа хамт олны хуралд тайлагнаж 2009 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, чиглэлээ тодорхойлж аймгийн БСГ-ын даргатай үр дүнгийн гэрээ байгуулж ажилласан. - Салбарын ажилтан, ажилтнуудтай уулзаж санал бодлыг нь сонсож салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох ажил хийгдсэн. - Соёлын ажилтны ажлын түвшин тогтоох ажлын удирдамж боловсруулж, соёлын ажилтнуудын ажлын түвшин тогтоох ажлыг удирдаж зохион байгуулсан. - Аймгийн Засаг даргын нэрэмжит хүүхдийн урлаг, уран бүтээлийн “Авьяс-2009” уралдааныг 2009 оны 3-р сард зохион байгууллаа. - Хөгжимт драмын театр, Музей, Номын сангийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж өнөөгийн үйл ажиллагаа цаашид хийх зүйлийн тухай зөвлөгөө өгч ажиллаа.
---	--	--

		<p>- Олон улсын Хөөмийн наадам, эрдэм шинжилгээний хуралд манай аймгаас МУГЖ Э. Тойвгоо тэргүүтэй баг бүрэлдэхүүн оролцож амжилттай оролцоод ирсэн.</p> <p>ОХУ-ын Халимаг улсын Элиста хотод зохиогдсон “Монгол хэлтэн туургатны V их наадам”-д манай 15 уран бүтээлч амжилттай оролцоод ирлээ.</p>	
<p>Стратегийн зорилт 2. Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Монгол Улсын үндэстэн, ястан, үндэсний цөөнхийн болон хүн ам зүйн янз бүрийн давхрагуудын оюуны хэрэгцээг үе шаттай судлан тодорхойлж, тэдгээрт тохирсон соёл, урлагийн үйлчилгээний төрөл үр ашигтай арга хэлбэрийг сонгож хэрэглэх ▪ үндэсний монгол бичгээ өвлүүлэн хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ▪ монголчуудын уламжлалт соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, сэргээх, үндэсний хийгээд дэлхий дахины танин мэдэхүй, боловсролын нийтлэг хүртээл болгон дэлгэрүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжих ▪ үндэсний уламжлалт болон сонгодог урлаг, хүүхдэд зориулсан урлагийн төрлийг төрөөс дэмжих үндэсний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх ▪ соёл, урлагийн байгууллагуудын материаллаг бааз, барилга байгууламжийн зориулалт, эрүүл ахуй, гоо зүй, техникийн болон 	<ul style="list-style-type: none"> ▪ Аймгийн ХДТ-ын жүжиг ангийн багш Ц.Лхагва нь Д.Мягмарын “Найрын ширээний ууц” жүжгийг “Хөдөөгийн баг-62” төслийг аймгийн Засаг даргын тамгын газар, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулж хөдөөгийн 18-аад сумын 62 багт очиж урлаг соёлоор үйлчилж давхардсан тоогоор 67000 хүнд хүрч үйлчлэн унаа тээврийн зардлын тооцоо хийгээд 2.200.000 төгрөгийн орлого олсон байна. Мөн “Икэлийн эгшигт нутаг” концерт, Өвөл цагийн нээлтийн “Алтай Ханы аялгуу” концерт, бусад тоглолт үйлчилгээнд оролцон ажиллалаа. ▪ ХДТеатр Д.Мягмарын зохиол “Найрын ширээний ууц” инээдмийн жүжгийг шинээр найруулан тавьсан. Мөн Баруун Ойрадын урлагийн гайхамшгийг монголдоо төдийгүй гадаад сурталчлах зорилгоор “Хан Алтайн зарлиг” бүрэн хэмжээний концертыг найруулан тавьж төвийн өндөр ур чадвартай бүжиг дэглээч төрийн соёрхолт, Урлагийн гавъяат зүтгэлтэн С.Сүхбаатар, найрал дууны багш, хормейстр Буян-Орших, зураач Урантуяа нарыг урьж ирүүлж ажиллуулж хувцас хэрэглэл, тайз декрацын өвөрмөц шийдэл гарган ажилласан. ▪ БСШУЯам, НҮБ-ын Юнеско, ШУАкадемитай хамтран орон нутгийн соёлын байгууллагуудын удирдлага, аймгийн соёлын мэргэжилтэн хамтарсан баг 	<p>90</p>

	<p>үйлчилгээний чанарт тавигдах орчин үеийн хэрэгцээ шаардлагыг тусгасан стандартыг боловсруулж мөрдөх</p>	<p>бүрэлдэхүүнтэйгээр Биет бус соёлын өв, Утга соёлын өвийн тухай нарийвчилсан судалгаа хийж баримтжуулах ажлыг зохион байгуулсан</p> <ul style="list-style-type: none"> ▪ ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссоос гаргаж байгаа Монголын Тахилгат газрын тухай дэлхийн номонд Увс аймгийн 157 тахилгат газрыг орууллаа. ▪ Утга соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд: <ul style="list-style-type: none"> - 157 тахилгат газрын тодорхойлолт - 13 утга соёлын өв багтсан язгуур урлагийг дүрсжүүлсэн бичлэг - 150 гаруй дөрвөд ардын уртын дууны үг, 5 ерөөл багтсан Г.Намсрайн “Үе дамжсан язгуур” номноос авч гаргаж хүргүүлсэн. ▪ Сар бүр 3-аас доошгүй кино үзвэр, уран сайханч, ардын авъяастнуудын тайлан тоглолт, уралдаан тэмцээнийг санаачлан зохион байгуулж үзэгчдийн дунд тогтмол ажил болон өргөжиж байна. ▪ 1-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд “Жижиг шувууд”, Таван тэс бага сургуулийн Баруунтуруун багштай 1-р ангийн сурагчдад “Увс аймгийн ан амьтад” сэдвээр 2 удаа экскурс хичээл зохион байгуулсан. ▪ САМА орон нутгийн телевизээр “Үндэсний хувцас” шоу нэвтрүүлэг, МВС телевизтэй хамтарч Маршал Ю.Цэдэнбалын тухай нэвтрүүлэг, цаг агаарын фон сурталчилгааг тус тус бэлтгэж олон нийтийн хүртээл болголоо. ▪ “Миний нутаг мянган дурсгалын өлгий” үзэсгэлэн, Маршал Ю.Цэдэнбалын музейд шинэчлэн дэглэсэн. ▪ Аймгийн Музей нээлттэй хаалганы өдрүүдээр байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчлан оролцож 50ш музейн товч танилцуулга, 30ш товхимолыг ард иргэдэд үнэгүй тараасан. 1 өдрийн турш 500 гаруй хүнд музейг 	
--	--	---	--

		<p>үнэ төлбөргүй үзүүлэн үйлчилсэн.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Аймгийн хэмжээний 44 номын санд 80 гаруй сая төгрөгийн шинэ ном хүргэх асуудлыг БСШУ-ны яам, ҮНС, Монголын хүүхдийн ордонтой хамтран зохион байгууллаа. ▪ Сумын номын сан ондоо дунджаар 4.500.000 төгрөгийн 900-аас доошгүй нэрийн номоор баяжуулсан байх ёстойгоос нийт 8.362.620 төгрөгийн 1244ш номоор фондоо баяжуулж нэмэгдүүлсэн. ▪ Номын сангийн вэб хаягийг шинээр нээж, фондын нийт номын 60%-ийг электрон каталогт орууллаа. ▪ Номын сангийн бүх танхимыг дотоод сүлжээтэй болгож, интернэтэд холбогдлоо ▪ Номын сангийн үйл ажиллагааг улсын болон орон нутгийн телевиз, радио, сониноор 15 удаа сурталчилгаа хийсэн <p>Номын сан нээлттэй хаалганы өдрийг 3 удаа зохион байгуулж, олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.</p>	
--	--	---	--

4.8. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлого

Хүн амын орлого багатай эмзэг хэсэгт түлхүү хандсан нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ. Нийгмийн хамгаалалд оруулж байгаа хөрөнгө бол хойч үедээ оруулж байгаа хөрөнгө оруулалт гэж үзнэ. Нийгмийн хөгжлийн оновчтой бодлого хэрэгжүүлсний үндсэн дээр хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчин бүрдүүлж, монгол хүний аж амьдралын чанарыг сайжруулна.

<p>Стратегийн зорилт 1. Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн хэрэгцээ, сонголтод түшиглэсэн халамжийн олон талт үйлчилгээг бий болгож, үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор хүргэх тогтолцоог бүрдүүлэх ▪ хөдөөгийн хүн амд зориулсан нийгмийн явуулын үйлчилгээг хөгжүүлэх 	<p>Нийгмийн халамжийн үйлчилгээний нэг төрөл болох олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээг /ОНОТХҮ/ зорилтот бүлгийн иргэдэд хүргэх, хүмүүст сурталчлах ажилд түлхүү анхаарч ажиллаа.</p> <p>Аймгийн хэмжээнд зорилтот бүлгийн 59 өрхийг ядуурлаас гаргах, амьжиргааны эх үүсвэртэй болоход нь зориулж зохион байгуулалттай хөдөлмөр эрхлэх 32 бүлэг үүсгэн нийт 20 сая төгрөгийг уг зардлаас санхүүжүүлэн олголоо. ОНОТХҮ-ний нэг хэлбэр болох нөхөн сэргээх үйлчилгээг аймгийн Ахмадын хороо ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж 2 сая</p>	<p>90</p>
---	---	---	------------------

		<p>төгрөгөөр санхүүжүүлэн Улаангом сумын 2000 гаруй ахмадад уг үйлчилгээг хүргэж байна.</p> <p>Байнгын асаргаа шаардлагатай эмзэг бүлгийн иргэдийг сэргээн засах үйлчилгээг гэрээр үзүүлэхэд зориулан мэргэжлийн сувилахуйн “Энэрэл” ТББ-д 14,4 сая төгрөгийг төсөл шалгаруулах замаар гэрээ байгуулан санхүүжүүлж, хяналт тавин ажиллаж байна.</p>	
<p>Стратегийн зорилт 2. Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг өргөжүүлж, ажил олгогч, ажил хайгчид, мэргэжлийн сургалтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах ▪ хөдөлмөрийн гадаад болон дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх замаар гадаадад ажиллах хүч гаргах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх ▪ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг сайжруулах, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх замаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох ▪ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний хүрээнд төрөлжсөн бизнес инкубаторыг байгуулан ажиллуулж, жижиг зээл, ажлын байран дахь болон шавь сургалтыг өргөтгөх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ▪ мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хувийн хэвшлийн оролцоог дэмжих замаар бэлтгэгдэж байгаа 	<p>Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг өргөжүүлж, ажил олгогч, ажил хайгчид, мэргэжлийн сургалтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах олон талт ажлууд зохион байгууллаа.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн ажлын хэсгийг байгуулан, хийх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.</p> <p>Мэргэжил олгох сургалтанд ажилгүй, ядуу, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг жигд хамруулан сургахаас гадна ажил олгогч байгууллагын захиалгаар албан бус салбарт ажиллагсдыг сургах чиглэл баримтлан 2009 оны сургалтын хэрэгцээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласны үр дүнд жил эцсийн байдлаар 22 төрлийн мэргэжлээр 605 хүнийг сургаж мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ олголоо.. Дээрх сургалтанд хамрагсдын 58 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байсны дээр сургалтанд хамрагдагсдын 70 хувь нь ажлын байртай боллоо.</p> <p>Аймаг сумын хэмжээнд нийтийг хамарсан ажлын 54 төсөл шалгаруулан зохион байгуулж 1496 ажилгүй иргэдэд түр ажлын байр бий болгосноос гадна эмзэг бүлгийн 1110 иргэд уг ажилд хамрагдаж, тэдэнд 101.9 сая төгрөгийн цалин хөлс олголоо.</p>	<p>90</p>

	боловсон хүчний чадавхийг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх		
Стратегийн зорилт 3. Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ▪ эмэгтэйчүүд, ахмад настан, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын болон нийгмийн бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлж, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ▪ гадаадад ажиллаж, амьдарч байгаа, өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн монгол иргэдийг эх орондоо буцаж ирж ажиллах сонирхлыг төрүүлэхүйц эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, өөрийн мэргэшсэн чиглэлээрээ ажлын байр бий болгох санал санаачилгыг хөхиүлэн дэмжих ▪ албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх 	Аймаг сумын хэмжээнд 25 буюу түүнээс дээш ажиллагсадтай 109 аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг гарган шалгалт хийж ХБИ-ийг ажииллуулаагүй байгууллага аж ахуйн нэгжид зөвлөгөө өгч төлбөр төлүүлэх талаар анхааруулга мэдэгдэл өглөө. 2009 онд 4 байгууллагаас 1555200 төгрөгийн төлбөрийг тусгай дансанд хуримтлууллаа. Төрөл бүрийн сургалтанд 58 ХБИ-ийг хамруулж, 55 хүнийг ажлын байртай болгох зорилгоор 22967,0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг төслийн хэлбэрээр санхүүжүүллээ. Бичил зээлийн үйлчилгээнд 12 ХБИ-ийг хамруулж 12.0 сая төгрөгийн зээл тусламж олголоо. Аж ахуй эрхлэх, төсөл хөтөлбөр боловсруулах сургалтыг 9 удаа зохион байгуулж 200, малчны сургалтыг 4 удаа зохион байгуулж 100 хүнийг тус тус хамрууллаа. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн судалгааг гаргаж, тэдний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн чадавхжуулах	90
Стратегийн зорилт 4. Нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.	<ul style="list-style-type: none"> ▪ олон давхаргат болон олон сонголтот тэтгэврийн тогтолцоо бүрдүүлэх ▪ хуулийн этгээдэд ажиллаж байгаа хүн бүр нийгмийн даатгалд заавал хамрагдах зарчимд шилжих ▪ цэргийн албан хаагчдын болон бүх нийтийн тэтгэврийн 	Хуулийн этгээдэд ажиллаж байгаа хүн бүр нийгмийн даатгалд заавал хамрагдах зарчимд шилжих ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн татварын албанд бүртгэлтэй ажил олгогчдын тооллого явуулж, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогчдыг Татвар, МХГ, барилга хот байгуулалтын албатай хамтран харилцан мэдээлэл	90

	<p>даатгалын оновчтой бодлогыг хэрэгжүүлж, даатгалын сангийн бүрэн хуримтлалын тогтолцоог бий болгох угтвар нөхцөлийг бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • нийгмийн даатгалын системийг зах зээлийн харилцааны зарчимд нийцүүлэн хөгжүүлж, нийгмийн даатгалын сангуудад хөрөнгө бүрдүүлэх механизмыг боловсронгуй болгож, бүрдсэн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах эрх зүйн орчинг төлөвшүүлэх 	<p>солилцож, ажил олгогч даатгуулагчдын хамрах хүрээг нэмэгдүүлэх, НДШ-ийн өр авлагыг бууруулах, сангийн орлого нэмэгдүүлэх ажлуудыг тодорхой үе шаттай төлөвлөн зохион байгуулж ажилласны үр дүнд шинээр 42 ажил олгогч, түүнд хамрах 71 заавал даатгуулагч болон 602 сайн дурын даатгуулагчийг нийгмийн даатгалд, 3965 даатгуулагчийг эрүүл мэндийн даатгалд шинээр хамрууллаа.</p> <p>Оны эхнээс нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд</p>	
--	--	--	--

5.1. Макро эдийн засгийн бодлого

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх макро эдийн засгийн нэн таатай орчинг бүрдүүлнэ.

5.1.1. Улсын төсвийн бодлого

Улсын төсвийн бодлого нь эдийн засгийн өсөлт болон төсөв санхүүгийн тогтвортой, тэнцвэрт байдлыг бататгаж, санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бодит салбарын хөгжлийг дэмжихэд бүрэн чиглэнэ. Төсвийн бодлогыг Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ. Ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулан ашиглаж, татвар, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамжийн орлогоос “Монгол Улсыг хөгжүүлэх сан”-д төвлөрүүлэн, иргэдэд хуваарилж, зохистой ашиглана.

<p>Стратегийн зорилт 1. Төсвийн төлөвлөлтийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд нийцүүлэн боловсронгуй болгоно.</p>	<ul style="list-style-type: none"> • Төсвийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан боловсруулж, хэрэгжүүлж байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох • орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн эрх хэмжээг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог 	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн 2009, 2010 оны төсвийн төслийг Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн жилүүдийн дэвшүүлсэн зорилтын хүрээнд боловсруулах арга хэмжээг хуулийн хугацаанд нь гүйцэтгэсэн болно. Орон нутгийн түвшинд бүтээгдэхүүн, хөтөлбөрт суурилсан дунд хугацааны төлөвлөлтийн зарчим тэр бүр хэрэгжихгүй байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн төсвийн зардлын зүйл ангиар төлөвлөж, гүйцэтгэлийн үр дүн ч тухайлсан төсөвт зардлаар илэрхийлэгдэж байна. 	<p>90</p>
--	--	--	------------------

	<p>сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> • төсвийг төсвийн байгууллагуудын бодит хэрэгцээнд нь нийцүүлэн төлөвлөж, санхүүжүүлэх; • төсвийн ил тод байдлыг хангах 	<ul style="list-style-type: none"> • Төсвийг тухайн оны бодлого зорилт, хөтөлбөртэй уялдуулан төсвийн байгууллагуудын бодит хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөдөг ч дээд шатанд танадаг, хасаж хянадаг байдал оршсоор байгаа тул тэр бүр салбарын бодлогын зорилтын хэрэгжилтийг хангах нь бодит үр дүнд хүргэдэггүй. Гэсэн хэдий ч батлагдсан төсвийнхөө хүрээнд боломжит эх үүсвэрийг дайчлан салбарын бодлого зорилтыг хэрэгжүүлэх, үүрэг хариуцлагыг чанд мөрдөн ажиллаж байна. 	
<p>Стратегийн зорилт 2. Төсвийн хөрөнгө оруулалтыг Мянганы хөгжлийн зорилтуудтай оновчтой уялдуулан нэмэгдүүлж, урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд суурилан хэрэгжүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ төсвийн хөрөнгө оруулалтыг зорилтот хөтөлбөрүүд, эдийн засаг, нийгмийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө, төслүүдэд тулгуурлан хуваарилах ▪ дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ▪ боловсрол, эрүүл мэндийн салбарт, ялангуяа бүс нутаг, хөдөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Мянганы хөгжлийн зорилтуудтай уялдуулан тогтмол нэмэгдүүлэх ▪ мэдээлэл, холбооны орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, мэргэжлийн боловсрол олгох тогтолцоог сайжруулахын тулд төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжлэг үзүүлэх 	<p>Увс аймагт 2009 онд улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сан, орон нутгийн замын сан, бусад төсөл хөтөлбөрөөр нийт 17474,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, их засварын ажил хийгдсэн. Үүнийг салбараар нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> • Боловсрол, соёлын салбарт 5286,3 сая • Эрүүл мэндийн салбарт 833,9 сая • ХАА-н салбарт 310,0 сая • Дэд бүтцийн салбарт 10616,5 сая • Орон нутгийн засаг захиргаа болон бусад салбарт 425.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, их засварын ажил тус тус хийгдсэн байна. 	90
<p>Стратегийн зорилт 3. Хүн амын орлого багатай ядуу болон дундаж орлоготой хэсэгт түлхүү хандсан төсвийн зарлагын бодлого</p>	<ul style="list-style-type: none"> ▪ ажлын байр шинээр бий болгох, бүх нийтийн боловсролын түвшинг дээшлүүлэх, эх, хүүхдийн эндэгдэл, халдварт өвчний тархалтыг бууруулахад зориулах төсвийн санхүүжилтийг 	<p>Бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд сумын Засаг дарга, сургуулийн захирал, албан бус боловсролын багш нар гэрээ байгуулан бичиг үсгийн зуны сургалт болон мэргэжил олгох, дараа шатны сургалтыг зохион байгууллаа. Бичиг үсгийн сургалтанд 350 хүн хамрагдаж, 200</p>	90

<p>хэрэгжүүлнэ.</p>	<p>нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> ▪ нийгмийн хамгааллын санхүүжилт, тэтгэвэр, тэтгэмжийг дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэй оновчтой уялдуулан нэмэгдүүлэх ▪ нийгмийн эмзэг бүлэгт зориулсан халамж, үйлчилгээний санхүүжилт болон ахмад настанд олгох санхүүгийн тусламжийг нэмэгдүүлэх 	<p>хүн бичигтэн боллоо. Иргэдийг мэргэжил олгох 12 курс дамжаанд хамруулан сургаснаар 215 хүнийг ажлын байртай болгов. Сумын сургуулиудын гэгээрэл төвийг түшиглэн эрүүл мэнд, эрх зүй, экологи, эдийн засаг зэрэг сургалтуудыг тусгай график хөдөлбөрийн дагуу иргэдийн дунд 253 удаа явуулж 36400 хүнийг хамруулав. Бүх нийтийн боловсролд зориулж улсын төсвөөс 108.4 сая төгрөг төлөвлөн зарцууллаа.</p> <p>НДС-аас 9199.2 сая төгрөгийг тэтгэвэр тэтгэмжинд зориулан зарцуулсан.</p> <p>Нийгмийн даатгалд 2009 онд 57331 хүн хамрагдсан.</p> <p>8.5 мянган хүн тэтгэвэрт, 2.3 мянган хүн тэтгэмжинд хамрагдаж 1 хүнд дунджаар сард 85.3 мянган төгрөгийн тэтгэвэр, 19.1 мянган төгрөгийн тэтгэмж ногджээ.</p> <p>Нийгмийн халамжийн сангаас давхардсан тоогоор 93.0 мянган хүнд 7 тэрбум 560.8 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлтүүд олгогдсон.</p> <p>Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн бүтцийг авч үзвэл 11.2 хувь нь халамжийн тэтгэвэрт, 3.9 хувь нь нөхцөлт мөнгөн тэтгэмжид, 36.4 хувь нь улсын төсвөөс олгосон тэтгэмжид, 41.5 хувь нь хүүхдийн тэтгэмжид (улиралд олгодог 25.0 мян.төг), 5.2 хувь нь ахмад настан, ХБИ-дэд олгосон хөнгөлөлт, 1.9 хувь нь нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжид тус тус зарцуулагдсан байна.</p> <p>1 хүнд дунджаар сард 6.7 мянган төгрөгийн зарцуулалт ногдож байна.</p>	
	<p>Гадаадад өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд төсвөөс дэмжлэг үзүүлэх</p>	<p>Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу Энэтхэг, Малайз улсад аймгийн ИТХ, ЗДТГ-аас 5 хүнийг дунд хугацааны хөтөлбөрт сургалтанд</p>	

		хамрууллаа. Тэдний сургалтын зардалд орон нутгийн төсвийн давсан орлогоос 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.	
5.1.2. Татварын бодлого Татварын бодлогоор экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.			
Стратегийн зорилт 2. Экологийн татварыг бий болгож, татварын суурийг өргөтгөн татвар хураалтыг сайжруулж, төсвийн орлогыг зохистой нэмэгдүүлнэ.	Татварын нэр төрөл, татвар ногдуулах аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн, татварын орлогын болон эдийн засгийн өсөлтийн уялдаа холбоог хангаж, татварын ачааллыг зохистой түвшинд байлгах, татварын тогтолцоог боловсронгуй болгох	ААНОАТ-ын тухай хуулийн 19.9 заасны дагуу орлогын болон хөрөнгийн татварыг давхардуулж үл ногдуулах гэрээ бүхий улс орнуудын тоог нэмэгдүүлж, мэдээлэл харилцан солилцон ажиллаж байна.	90
	Орлогын болон хөрөнгийн татварыг давхардуулж үл ногдуулах гэрээ бүхий улс орнуудын тоог нэмэгдүүлж, мэдээлэл харилцан солилцох	Орлогын албан татвар 10 хувь бөгөөд энэ үзүүлэлтээрээ манайх хамгийн бага татвартай орны тоонд орж байна. Үл хөдлөх эд хөрөнгийн болон бусад өмчийн татварууд, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төсөв бүрдүүлэх үүргийг нэмэгдүүлэх зорилгыг өмнөө тавин ажиллаж байна.	
	Орлогын албан татварын хувь хэмжээг зохистой түвшинд хадгалж, хөрөнгийн болон хэрэглээний татвар, газар, агаарын орон зай, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамжийн төсөв бүрдүүлэх үүргийг нэмэгдүүлэх		
	Онцгой албан татварын нэр төрлийг нэмэгдүүлэх замаар зохисгүй хэрэглээг хязгаарлаж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл үйлчилгээнд экологийн татвар	Тус аймгийн нутаг дэвсгэрээс онцгой албан татварын нэг төрлийг хурааж байна. Цаашид онцгой албан татварын нэр төрлийг нэмэгдүүлэх замаар зохисгүй хэрэглээг хязгаарлаж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл үйлчилгээнд экологийн татвар ногдуулах бодлогыг төрөөс баримталж байгаа.	

	ногдуулах		
	Татварын илүү төлөлтийг буцаан олгох тогтолцоог нэвтрүүлэх	Одоогоор ийм тогтолцоо орон нутагт нэвтрээгүй байна.	
	Хуримтлагдсан татварын болон зээлийн албан татварыг бий болгох	ААНОАТ-ын тухай хуулийн 20 дугаар зүйлд татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох тухай заалт хэрэгжээд 3 жил болж байна. Харин хуримтлагдсан татварын болон зээлийн албан татвар бий болоогүй.	
	Далд эдийн засгийг ил болгох зорилгоор татварын өршөөл үзүүлэх болон зохицуулалтын бусад арга хэрэгслийг оновчтой ашиглах	2008 онд хэрэгжсэн “Татварын зарим хууль, нийгмийн даатгалын тухай” хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн хүрээнд 11 татвар төлөгчийн 7657.9 сая төгрөгийн орлогод ногдох 413.2 сая төгрөгийн ААНОАТ, НӨАТ, ҮХХ- ийн албан татвар, АТӨЯХ-ийн албан татвар хамрагдсан бол “татварын өршөөл үзүүлэх тухай” хуулийн хүрээнд 193 татвар төлөгчийн 195.3 сая төгрөгийн төтварын өр өршөөлд хамрагдлаа. Мөн татвар ногдох орлого, зүйлийг нуун дарагдуулсан этгээдийн талаар хөндлөнгийн мэдээлэл авч хяналт шалгалтанд ашигласанаар 36 этгээдийн 36.1 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн байна.	
5.1.5. Өрсөлдөх чадварыг сайжруулах бодлого Макро эдийн засгийн хөшүүргүүдийг хэрэглэн Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.			
Стратегийн зорилт 1. Монгол хүнийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ▪ монгол хүний техникийн болон удирдахуйн ур чадварыг тогтмол дээшлүүлэх, инженерийн болон мэргэжлийн сургалтыг сайжруулахуйц гадаад орны сургалтын тогтолцоог багшийнх нь хамт нутагшуулахыг дэмжих ▪ нарийн мэргэжлийн монгол ажилтан, ажилчдыг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх зорилт дэвшүүлж, хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • БСШУЯ-ны харъяа техник- технологийн Улаангом коллежид АНУ-ын Англи хэлний институтын 1 багш англи хэлний чиглэлээр, Солонгос улсын 1 багш хоол үйлдвэрлэлийн технологийн чиглэлээр ажиллаж байна. Хоол үйлдвэрлэлийн технологийн лаборатори мастерийн газрыг хөрөнгө оруулалтаар Улаангом коллежид байрлуулан, 1 багшийг монголын нэг багшийн хамт 3 жилийн гэрээтэй ажиллууллаа. Солонгос улсад Улаангом коллежоос 6 багш, 4 сурагч тодорхой хугацаагаар 	90

		<p>дадлагажуулах сургалтанд хамруулж, газар тариалангийн үйлдвэрлэлийн багшийг бэлтгэж байна. АНУ-ын Англи хэлний институтаас ирсэн сургагч багш нь Америкийн соёлын төвийн салбарыг Увс аймагт байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд англи хэлний заах аргын сургалтыг явуулж 13 багшид сертификат олгосон.</p> <ul style="list-style-type: none"> • Аймагт 24 мэргэжлээр монгол ажилтан, ажилчдыг бэлтгэх сургалтыг явуулж сүүлийн 3 жилд 1500 гаруй хүнд мэргэжил эзэмшүүллээ. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар жил бүр 120 гаруй хүнийг мэргэшүүлэх ажлыг зохион байгууллаа. Энэ чиглэлийн чиг үүргийг Улаангом коллежийн дэргэдэх Баруун бүсийн сургалт арга зүйн төв, Бизнес инкубатор төв, хөдөөгийн иргэдийн хөгжлийг дэмжих олон улсын байгууллага Мерси-Корын Увс аймаг дахь салбар, Дэлхийн зөнгийн Увс аймаг дахь салбар гүйцэтгэж, тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт, дэмжлэг, сургалтууд хийгдэх боллоо. 	
--	--	--	--

5.1.6. Гадаад худалдааны бодлогын стратегийн зорилтууд

Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан эдийн засгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх гадаад худалдааны таатай орчинг бүрдүүлнэ.

<p>Стратегийн зорилт 1. Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг зохистой өсгөнө.</p>	<p>Эрдсийн болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг үе шаттай бууруулж, эцсийн бэлэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх</p>	<p>2009 онд 556.6 тн үхрийн мах, 744.4 тн адууны мах, 18 ш гэр экспортолж, гурил 6306.9 тн , бензин 10026.7 тн, дизель түлш 11255 тн, цахилгаан 66183.4 мян.квт.цаг, хивэг 452 тн, авто машин 16 ширхэгийг импортолсон байна.</p> <p>Одоогоор адуу, үхрийн маханд анхан шатны боловсруулалт хийж гаргаж байгаа. Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж нэмэгдүүлэх чиглэээр жил бүр Тува Хакас улсуудтай хилийн худалдаа зохион байгуулах, аймагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тус улсуудын зарим аж ахуй нэгжийг энэ үзэсгэлэнд урин оролцуулах зэрэг</p>	<p>90</p>
---	---	--	------------------

		ажлуудын зохион байгуулан хийж байна. Мөн Хандгайт боомтын орчимд эдийн засгийн худалдааны төв байгуулахаар Давст сумын нутгаас газар авах зэрэг ажлын эхлэл тавигдаад байна.	
	Оюуны шингэц бүхий бага оврын бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг өсгөх	Тус аймгийн бизнес эрхлэгчдийн чадамжийг дээшлүүлэх зорилгоор төслийн байгууллагуудтай хамтран аж ахуй хөтлөх мэнэжментийн сургалтуудыг зохион байгуулахаас гадна гадаад дотоодын үзсэсгэлэн оролцуулахад зуучлах, хөрш орнуудын өндөр технологиор бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүдтэй газар дээр нь очиж танилцах, мөн тэдэнд шаардлагатай байгаа тоног төхөөрөмж хэрэгцээт мэдээллээр хангах зэрэг ажлуудыг тогтмол гүйцэтгэж байгаа болно.	
Стратегийн зорилт 2. Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулан сайжруулна.	Импорт орлох зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих	Импорт орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр тус салбарж ажиллаж байгаа бизнес эрхлэгчдэд 709.0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл олголоо. Энэ хөнгөлөлттэй зээлийн хүрээнд аймгийн хэмжээнд 101 ажлын байр шинээр бий болж 18 жижиг үйлдвэр шинээр байгуулагдаж, ЖДҮ-үүд техник, тоног төхөөрөмжөө шинэчлэх, ажлын байраа өргөтгөх боломж бүрдлээ.	70
5.2.1.1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого Өндөр технологит тулгуурлан стратегийн орд газруудыг ашиглаж, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлж, эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулж, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох санхүүгийн чадамж, хуримтлалыг бүрдүүлнэ.			
Стратегийн зорилт 1. Стратегийн орд газруудыг ашиглана. Улсын зардлаар геологийн хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн орд газруудад төрийн мэдлийн хувийг 51-ээс дээш байлгах	Геологийн судалгаа, эрдэс баялгийн эрэл хайгуулын ажлыг өргөтгөх	Увс аймгийн хэмжээнд Ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын талаар 2009 оны шинэчлэгдсэн бүртгэлээр 183 аж ахуйн нэгж, иргэн 1192470.48 га талбайд хайгуул хийж байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 17.6 хувийг, 38 аж ахуйн нэгж 6050.32 га газарт ашиглалт явуулж байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 0.08 хувийг эзэлж байна.	90
	Ашигт малтмалыг бичил уурхайн хэлбэрээр	Бичил уурхайг хөгжүүлэх талаар сумдын удирдлагуудад уул	

<p>бодлогыг баримтална.</p>	<p>олборлох үйл ажиллагаанд төрийн зохицуулалтай, байгаль орчинд халгүй, хүний амьдрах орчинд аюулгүй байх зарчмыг баримтлан эрх зүйн орчинг бүрдүүлэх</p>	<p>уурхайн талаар анхны мэдэгдхүүн 2009.07.01-03 болсон БОАЖЯ-аас зохион байгуулсан семинар сургалтанд суулгаж зохих мэдлэгийг олгосон. Уул уурхайтай сумдын удирдлага байгаль орчны ажилтнуудтай хяналт шалгалтыг байнга хамтарч хийж байна.</p>	
<p>Стратегийн зорилт 2. Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална.</p>	<p>Уул, уурхайн ашиглалтанд өртсөн талбайн нөхөн сэргээлтийг сайжруулах</p> <p>Уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан гадаргын болон газрын доорхи усны экосистем доройтох, бэлчээр хомсдох зэрэг сөрөг нөлөөллийг багасгахад анхаарч экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор гол мөрний эх, ай сав, ойн бүс, говийн баян бүрд, нуур цөөрөм, түүхийн дурсгалт газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохгүй байх, цаашид хэсэгчлэн хязгаарлах зорилгоор үе</p>	<p>Байгаль орчны мэргэжлийн байгууллагуудын мэргэжилтэнүүдийг оролцуулан аймгийн хэмжээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, иргэний хөндсөн газрын хэмжээг хамрагдсан талбайн хэмжээг нарийвчлан хэмжиж газрын зурганд буулгах, нөхөн сэргээгээгүй эзэнтэй ба эзэнгүй орхигдсон, билогийн болон техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг тогтоох зорилгоор 2009 оны 6-р сард тооллогын ажлыг хийж нийт 318,8 га талбай хөндөгснөөс одоогийн байдлаар 52,3 га-д нөхөн сэргээлт хийгдэж 266,5 га-д одоогоор тодорхой хэмжээний нөхөн сэргээх үйл ажиллагаа хийгдээгүй байгаад цаашид бодлогын хэмжээнд төлөвлөлт хийх чиглэл барина.</p> <p>Гол мөрний ай сав газарт хайгуул ашиглалт явуулахыг хориглох тухай хуулийн хүрээнд тухайн сав газар болон ойн сан бүхий газарт олгогдсон лицензийг цуцлуулах, аймгийн хэмжээний гол мөрний болон ойн сан бүхий газруудын нэгдсэн судалгааг хийж тухайн газруудыг газрын зураг дээр буулгах ажлыг хийж ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохгүй байх зарчмыг баримтлана.</p>	<p>90</p>

	шаттай арга хэмжээ авч, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох		
5.2.1.2. Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого Өрсөлдөх чадвартай боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлж, эдийн засгийн төрөлжилтийг эрс сайжруулна.			
Стратегийн зорилт 1. Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд өрсөлдөх	Увс аймаг экологийн цэвэр бүтээгдэхүүнийг бий болгох улмаар экспортлох зорилгоор чацаргана хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаа болно. Энэ хөтөлбөрийн хүрээнд ард чацараганы түлхүү тарилаж эхэлж байгаа. Мөн аж ахуйн нэгж Япон улсад чацарганы шүүс гаргаж эхлээд байна.	90
	Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	Оёмол импортын бүтээгдэхүүний орлох бүтээгдэхүүнийг дэмжих зорилгоор 8 аж ахуйн нэгж иргэнд 97 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлийн дэмжлэг үзүүлэв. Жил бүр аймагт үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнүүдийг сутралчлах зорилгоор үзэсгэлэн худалодаа зохион байгуулж оёмол бүтээгдэхүүнүүдийг тусгай номинациар шалгаруулан урамшуулдаг.	
	Өөрийн оронд үйлдвэрлэх боломжтой хүнсний болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг хөгжүүлж, импортоос хэт хараат байдлыг багасгах	Аймгийн тэргүүн дэмжих үйлдвэрлэлийн салбаруудад хүнсний ард иргэдийн өргөн хэрэглээний барааг үйлдвэрлэдэг үйлдвэрүүдийг дэмжихээр бодлого боловсруулан ажиллаж байна.	
5.2.1.3. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн бодлого Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах таатай орчин бүрдүүлнэ.			
Стратегийн зорилт 2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно.	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгөх, үйлчилгээ	Аймгийн хэмжээнд Баруун бүсийн эдийн засгийг хөгжүүлэх “Баруун монгол” Төсөл “Дэлхийн зөн” төслийн байгууллага, Бизнес инкуватор төв, мөн бизнесийг дэмжих хувийн төрийн бус байгууллагууд жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд	90

	үзүүлэх үүрэг бүхий төвүүдийг аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд зохион байгуулж ажиллуулах	нь туслах, төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	
	Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодлогын асуудалтай холбоо бүхий аливаа шийдвэрийг гаргахдаа тэдний ашиг сонирхолыг илэрхийлэгч мэргэжлийн холбоодын саналыг авч тусгаж байх	Аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөлгөөнийг төр зсасгийн шийдвэр гаргагчид, мэргэжлийн холбоод банк санхүүгийн байгууллагууд бизнес эрхэлгчдийг оролцуулан 2 жил тутам зохион байгуулж бизнес эрхэлэхэд тулгарч буй саад бэрхшээл түүний даван туулах арга замын талаар хэлэлцэж зөвлөмж шийдвэр гарган хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн эдгээр зөвлөлгөөнүүд тавьсан илтгэл, санал, зөвлөмжийг ном болгон нэгтгэн хэвлэж нийтэд хүргэсэн.	
	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубатор байгуулж ажиллуулах	Бизнес инкуватор төвийг 2005 онд байгуулан ажиллаж байна. Энэ хугацаанд Бизнес инкубатор төвийн багш нарыг сургаж, бойжигчдыг шаардлагатай мэдээллээр ханган хөнгөлөлттэй зээлд хамруулан ажиллаж байна.	
	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдож байгаа тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд бүрэн шилжүүлэх	Аймгийн хэмжээнд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулийн дагуу олгодог согтууруулах ундаа зарах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг холбогдох яамнаас гаргасан журмын олгож нийтэд мэдээлэн ажиллаж байна.	

5.2.1.4. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого

Хөдөө аж ахуй, хүнсний салбарын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эрсдэл даах чадавхийг бэхжүүлэх замаар орчин үеийн хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолбор болгон хөгжүүлж, хүн амын гурил, мах, сүү, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, хүртээмж, чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг сайжруулна.

<p>Стратегийн зорилт 1. Бүс нутгийн онцлогыг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан малыг эрүүлжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортыг нэмэгдүүлнэ</p>	<p>Монгол малын тэсвэрт чанарыг бататган, цус ойртохоос урьдчилан сэргийлж, биологийн боломжийг бүрэн ашиглаж, байгалийн эрсдэл даах чадварыг нь бэхжүүлэх</p>	<p>Цөм сүрэг бүхий сумуудад өсвөрийн хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулан сүргийг сэлбэх, баталгаажсан хээлтүүлэгчийг үржилд ашиглах сүлжээ бий болгон ажиллаж байна.ЦСҮҮҮГ-т 3220 хонь, 256 ямаа үржүүлж байна. Жил бүр хээлтүүлэгчийг үзлэг аттестатчлалд хамруулах ажлыг зохион байгуулж хийдэг. 2009 онд 19.9 мянган хээлтүүлэгч үзлэг аттестачлалд хамрагдаж 98 хувь нь жишигт тэнцэж баталгаажсан.</p>	<p>90</p>
	<p>Малын чанар, үржлийн ажлыг сайжруулах Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах;</p>	<p>Баяд үүлдэрийн хонь бүхий Малчин, Хяргас, Зүүнговь,Тэс Өлгийн улаан омгийн ямаа бүхий Өмнөговь,Өлгий, Наранбулаг, Тэс хэвшлийн адуу бүхий Тэс, Зүүнговь сумуудын малаас шилэн сонголт хийж, аттетатчлалд хамруулан баталгуужуулж цөм сүрэг бүрдүүлэн, өсвөрийн хээлтэгч болон хээлтүүлэгч бойжуулан өөрийн аймгийн сумууд болон өөр аймагт сайжруулагчаар худалдаалдаг. Энэ онд 680 хурган хуц, 200 охин төлөг, 130 ухна бойжуулсан.</p> <p>Бүх сумдын бэлчээр ашиглалтын зургийг шинэчилсэн. Бэлчээрийн ашиглалт, эзэмшилтийг сайжруулах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх талаар мэдлэг мэдээлэл олгох чиглэлээр Тогтвортой амьжиргаа-II төслөөр бүх сумдын газрын даамал, ХХАА-н мэргэжилтэн нарыг сургалтанд хамруулсан. Сумууд бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах зорилгоор өвөлжөө, хаваржааны бэлчээрийг чөлөөлөх намар, зуны бэлчээр нутгийг хувиартай</p>	

		<p>ашиглах талаар сумын Засаг даргын захирамж гаргаж мөрдлөг болгон ажиллаж байна.</p>	
	<p>Бэлчээрийн газрыг ашиглах, эзэмших харилцааны эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлж, уламжлалт аргад тулгуурласан бэлчээрийн менежментийг боловсронгуй болгож, бэлчээрийн даацад зэрлэг амьтны бэлчээр, тэжээлийн хэрэгцээг оруулан тооцох зарчмыг баримтлах;</p>	<p>Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох, бэлчээр ашиглалтыг сайжруулах, малчдын мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, уламжлалт арга ажиллагааг сайжруулах зорилгоор Алтай соёны уулархаг нутгийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах төслөөр Тариалан, Түргэн, Сагил, Бөхмөрөн, Ховд, Улаангом сумдын малчид, малчдын бүлгийн төлөөлөлд “Малчдын бүлэг”, “Бэлчээрийн менежмент” сэдвүүдээр 2 удаа сургалт зохион байгуулсан.</p> <p>Алтай соёны төслийн зохицуулагч, УНАСУТХГХЗ-ны мэргэжилтэн, АЗДТГ-ийн мэргэжилтэн нар Монгол -алтайн нурууны биологийн төрөл зүйлийг хамгаалах стратеги төлөвлөгөө боловсруулах уулзалтанд 2 удаа оролцсон. Энэ стратеги төлөвлөгөө 2010 онд батлагдан хэрэгжиж эхлээд байна. Тус стратегид зэрлэг ан амьтдыг хамгаалах бэлчээр нутгийг зааглан тогтоох талаар нарийн тусгагдсан.</p>	
	<p>Малчдыг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх болон мал аж ахуй эрхлэх арга ухааны чиглэлээр малчдын дунд албан бус сургалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх</p>	<p>Олон улсын байгууллага Мерси кор төсөл, Дэлхийн зөн “Малчдын амьжиргааг дэмжих” төсөл, ДБС, Алтай соёны эко бүсийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах төсөл хөтөлбөрүүдийн оролцоотойгоор малчдын хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, байгаль цаг уурын өөрчлөлттэй уялдуулан мал аж ахуй эрхлэх арга ухааны хэв шинжийг өөрчлөх зэрэг чиглэлээр 6 удаа сургалт хийсэн. Улаанзагалмайн хороо,ХАА-н банкттай хамтран малчдын сургалт, семинар, зөлөгөөн зохион байгуулсан. 2009 онд бүсчилсэн хэлбэрээр бүх сумын малчдыг</p>	

		хамруулан зөвлөгөөн зохион байгуулсан. Мерси кор төслөөр АЗДТГ, ХХААЖДҮГ-ын мэргэжилтэн, сумдын ХХАА-н мэргэжилтэн нарт “ Мал аж ахуйн салбарын талаарх хууль тогтоомж “ сэдвээр сургалт зохион байгуулж, сургагч багш бэлтгэж, малчдад хууль сурталчлах нэг сарын хугацаатай “ Аян”-ы богц аялуулж ажлыг нь дүгнэсэн.	
Стратегийн зорилт 2. Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Газар тариалангийн болон эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа газрыг өмчлүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн тооллого хийж газрыг эзэмшүүлсэн. Фермерийн аж ахуй эрхлэгч нарт шинээр газар олгож эзэмшүүлэх, санхүү зээлийн дэмжлэг үзүүлж байна. 2009 онд сүүний чиглэлийн үхрийн, ямааны, үржлийн болон махны чиглэлийн хонины зэрэг хагас суурин 4 фермерийн аж ахуй шинээр байгуулагдсан.	90
	Услалтын оновчтой системийг бий болгон усалгаатай газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг лизингээр олгох, усжуулалтын барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтыг зах зээлийн зарчимд нийцүүлж сайжруулах	Инженерийн болон энгийн хийцтэй услалтын системийн ашиглалтанд байнгын хяналт тавин ажиллаж байна. Тариалж буй талбайн 90 гаруй хувь энгийн болон инженерийн хийцтэй усалгаатай талбай эзэлж байна. 2009 онд Сагил сумын Сэнж, Улаангом сумын Бор толгой, Түргэн сумын Хээр морьт, УГТЭШХ-ийн услалтын системүүд шинээр баригдаж, Улаанхотгорын 72 га талбайд засвар шинэчлэлийн ажил хийгдэж, усалгаатай талбай 465 га-аар нэмэгдэх боломж бүрдсэн. Иргэн аж ахуйн нэгжүүд усалгааны бага оврын тоног төхөөрөмжийг ашиглан тариалалт эрхэлж байна.	
	Богино хугацаанд түргэн боловсордог чанартай үрийг өргөн хэрэглэж, таримал ургамлын нэр төрлийг олшруулах	Аймгийн хэмжээнд төмсний эрт болцтой Накара, эрт ургацын байцаа номерпервы сорт тариалж иргэдийн хэрэгцээнд нийлүүлж байна. Чацаргана, Элизавета, витаминная, Минуса, солнечная, обильная, любимая, үхрийн нүдний - Алей, шар манжингийн Швейдская жолтоя, луувангийн - Шантеская, хүрэн манжин -	

		Бордов, сонгины- Бесонский, байцааны- Белорусский сортууд болон хулуу, хурган гуа зэрэг ургамлыг шинээр тариалж байна.	
	Жимс, жимсний мод үржүүлгийн газруудыг байгуулж, жимс, жимсгэний тариалалтыг өргөтгөх	Тус аймагт 2 иргэн, 4 аж ахуйн нэгжид жимс жимсгэнэ, мод үржүүлгийн тусгай зөвшөөрөл олгож жимс жимсгэнэ, чацаргана, төрөл бүрийн модны суулгац үйлдвэрлэж өөрийн аймаг болон УБ хот гадны аймгуудад нийлүүлж байна.100 гаруй га-д жимс жимсгэнэ тариалсан.	
	Таримал ургамлын өвчин, хортонтой тэмцэх, сорт, сорилтын чанарыг сайжруулж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх	Таримал ургамал ялангуяа төмс, хүнсний ногооны өвчин хортонтой тэмцэх бодис захиалан авч хэрэглэж байна.2009 онд Улаангом, Тариалан, Түргэн сумын таримал ургамалд нугын бор эрвээхэйн өвчлөлт бий болж 250 гаруй га талбайн ургац алдсан. Агро парк төслийн хүрээнд сум бүрт 120м ² багтаамжтай хүлэмж баригдсан. 2008 оноос иргэн, аж ахуйн нэгжүүд хувийн хөрөнгө оруулалтаар Солонгос улсын 60 м талбай бүхий хүлэмж оруулж ирж ашиглаж байна.	
Стратегийн зорилт 3. Хүнсний үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулна.	Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний болон импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	ХААСХТ, Мерси кор , чацаргана зэрэг төсөл хөтөлбөрийн хүрээнд: Газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж бизнесүүд төрөл бүрийн сургалтанд хамрагдаж мах, сүү, жимс жимсгэнэ, хүнсний ногоог боловсруулж импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж иргэдийн хэрэгцээнд нийлүүлж байна. Үүнд: Үхрийн нүд, чацаргана, хүрэн манжингийн жүүс, сироп, чацарганы тос, зөгийн бал,төрөл бүрийн салат,жимсний варень, чанамал, хорхой ааруул, хэвийн ааруул, шар шүүс, төрөл бүрийн хиам, гахайн утсан мах, сосесик, сала, гэх мэт	90
	Орчин үеийн техник, технологтой хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэн хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй	Улаангом суманд 8 цагт 1.5 тн чацаргана боловсруулах, Баруунтуруун суманд төмс, хүнсний ногоо хатаах даршлах үйлдвэр ашиглалтанд оруулж	

	<p>хүнсээр жигд, хүртээмжтэй хангаж, гадаад зах зээлд нийлүүлж эхлэх</p>	<p>чацарганы жүүс, сирип, хатаасан хүнсний ногоо боловсруулж иргэдийн хэрэгцээнд нийлүүлж байна. Ус- эрдэнэ ХХК сүүлийн 3 жилд Япон улсад 180 кг чацарганы тос экспортонд гаргасан.</p>	
	<p>Тохиромжтой бүс нутгуудад бөөний худалдааны төв, бирж байгуулж, хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох</p>	<p>Хүнсний бүтээгдэхүүний бөөний цэгүүд олноор байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байна. 2009 онд нэг цэгийн үйлчилгээ ашиглалтанд орсон.Бөөний худалдааны бирж байгуулахаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.</p>	
<p>Стратегийн зорилт 4. Газар тариалангийн болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ, шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Ашиглагдахгүй байгаа бэлчээрийг худаг гаргаж, хурын ус хуримтлуулж, булаг шандны усыг нэмэгдүүлж, усжуулах</p>	<p>Ашиглагдахгүй байгаа бэлчээрт худаг гаргах зорилгоор 2007 онд 19 сумын 50 цэгт усны геофизикийн хайгуул хийлгэсэн. Байгаль орчны яамны” Цөлжилттэй тэмцэх хороо”-ны хөрөнгө оруулалтаар 2008 онд 10 суманд 12, 2009 онд 8 суманд 8 булаг шандын эхийг хашиж хамгаалан, тохижуулах ажил хийгдсэн. Тогтвортой амьжиргаа-II төслийн хөрөнгөөр 4 сумын нутагт 4 булаг шандын эхийг тохижуулсан.</p>	<p>90</p>
	<p>Малчдын ундны усны хүрэлцээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах</p>	<p>Жил бүр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн зориулалттай инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаж байна. Сумдаас ирсэн захиалгын дагуу 2009 онд 10 сумын нутагт 15 ш инженерийн хийцтэй гүн өрмийн худаг шинээр гаргаж, гадна байгууламжийг зураг төсвийн дагуу барьж малчид, малчдын бүлэгт эзэмшүүлэх ажил хийгдсэн.</p>	
	<p>Зарим голын усны урсацын Тохируулга хийж бороо, цасны усыг хуримтлуулан гантай, хуурай үед ус хэрэглэх зориулалттай гидротехникийн байгууламжуудыг бий болгох</p>	<p>Усны нөөц тогтоох, хаврын шар ус,цас борооны усыг хуримтлуулах, инженерийн хийцтэй барилга байгууламж барьж, нөөцлөгдсөн усыг бэлчээр, хадлангийн талбай услахад ашиглах талаар судалгааны ажил хийгдэж байна. 2009 онд Түргэн сумын хээр морьтод 5000м³ багтаамжтай ус</p>	

		хуримтлуулах хүнхээл шинээр барьсан.	
Стратегийн зорилт 5. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	“Тэжээл” хөтөлбөр хэрэгжүүлж, малын тэжээл, усны хангамжийг сайжруулах	Сумдад хадлан тэжээл бэлтгэх ажлыг эрчимжүүлэх, иргэдийн идэвхи, санаачлагыг өрнүүлэх зорилгоор болзолт уралдаан зарлан шалгаруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Иргэд болон улсын нөөцийн салбар хадлангийн нөөц бүхий Тэс,Баруунтуруун, Өндөрхангай Бөхмөрөн, Тариалан, Давст, Наранбулаг, Сагил сумдын нутаг болон Ховд, Хөндлөнгийн голын ай сав газруудаас байгалийн хадлан бэлтгэж байна. Тус аймаг жилд дунджаар 40- 45тн байгалийн хадлан, 1800-2300 тн гар тэжээл, 1000 тн орчим үйлдвэрийн тэжээл, 850- 1200 тн ногоон тэжээл бэлтгэдэг. Малчид өөрсдийн хүч хөрөнгөөр өвөлжөө, хаваржааны орчмын талбайг хашиж хамгаалан хадлан бэлтгэх ажил хийж байна. Шимт чанар сайтай тэжээлийн ургамлыг хадаж өвсөн дарш, багсармал, холимог тэжээл, гар тэжээл бэлтгэх арга технологийг гарын авлага болгон бэлтгэж сумуудад хүргүүлсэн.	90
	Малын тэжээлийн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээний эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, төрийн бодлогоор дэмжих	Бага оврын тэжээлийн үйлдвэр байгуулах зориулалтаар Тариалан сумын 2 иргэнд ЖДҮДС-аас 23.0 сая төгрөгний зээлийн дэмжлэг үзүүлсэн. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглахад бэлэн болсон.	
	Шимт чанар сайтай, ургац ихтэй тэжээлийн шинэ төрлийн таримал нутагшуулах, үр үйлдвэрлэлийг дэмжиж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, фермерийн аж ахуйг тэжээлийн ургамлын үрээр хангах тогтолцоо бүрдүүлэх	Иргэн, аж ахуйн нэгжүүд шим тэжээл сайтаа царгасны үр бэлтгэн газар тариалан эрхлэгч нарт нийлүүлж байна. Баруунтуруун сумын Хар цагаан усанд туршилтын журмаар 0.4 га-д өвөлжих хөх тариа тариалсан.	
	Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэл даах чадавхийг	ХАА-н банк, Улаанзагалмайн хороотой хамтарч сайн малчдын	

	нэмэгдүүлэх зорилгоор жилийн тодорхой хугацаанд малаа тэжээдэг малчдын арга ажиллагааг дэмжин хөгжүүлэх	зөвлөгөөн зохион байгуулж зөвлөмж гаргаж, малчдад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Малыг тэжээх, турж сульдаж доройтсон малыг тэжээж тэнхрүүлэх талаар зөвлөмж гаргаж бүх сумдад хүргүүлсэн.	
Стратегийн зорилт 6. Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ.	Химийн аргаар боловсруулах уриншийн хэмжээг нэмэгдүүлэх	2009 онд Баруунтуруун суманд 2 иргэн, 12 аж ахуйн нэгж 910 га талбайд химийн уринш бэлтгэсэн.	90
	Дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөдөө аж ахуйн машин, техникийг худалдан авахад аж ахуйн нэгж, фермерүүдэд төрөөс дэмжлэг үзүүлэх	Агропарк төслийн хүрээнд: 19 суманд бага оврын трактор 12ш, 30тн-н багтаамжтой зоорь 19ш, 120 м ² багтаамжтай хүлэмжийн дэмжлэг үзүүлсэн. 2009 онд 15 ш бага оврын трактор дүүжин чиргүүл, агрегатын хамт авах санал, захиалгыг ХХАХҮЯ-нд хүргүүлсэн хэдий нийлүүлэгдэж чадаагүй.	
	Тариалангийн талбайг сүрлэн хучлагатай болгож хашаалан хамгаалах	Иргэн аж ахуйн нэгжүүд сүрлийг талбайд цацаж, сүрлэн хучлага бий болгох, талбайгаа хашиж хамгаалах ажил бүрэн хийгдэж байна. Талбайд бургас, улиас, хайлаас, саваа мод зэрэг суулгац тариалж ойн зурвас бий болгох ажил хийгдэж байна.	
Хөрсний үржил шимийг хамгаалах талаархи эрх зүйн орчин, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох	Ээлжлэн тариалах системийн технологээр үржил шимийг сайжруулж байна.		

5.3.1. Зам, тээврийн хөгжлийн бодлого

Стратегийн зорилт 2. Авто замын сүлжээг өргөжүүлнэ	<ul style="list-style-type: none"> ▪ “Мянганы зам”-ын хэвтээ, босоо тэнхлэгүүдийг барьж дуусгах ▪ дэд бүтцийн зарим босоо тэнхлэгийн дагуух хатуу хучилттай авто замыг барьж дуусгах ▪ бүсийн болон аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай замаар, дараагийн шатанд өөр хооронд нь холбох 	“Мянганы зам”-ын хэвтээ, босоо тэнхлэгүүдийн замын Улаангом-Ховд, Улаангом-Тосонцэнгэл чиглэлийн зам барьж эхлэх ямар нэг төсөл арга хэмжээ байхгүй болно. Энэ ажлын зураг төсөл хайгуул бараг хийгдээгүй байна. Баруун бүсийн аймгуудад одоогоор Ховд-Баян-Өлгий-Завхан аймгуудыг хатуу хучилттай замаар холбох бодлого хэрэгжиж байгаа тул Увс аймгийн талаар ойрын төлөв мэдэгдээгүй байгаа юм.	70
---	--	--	-----------

5.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого

<p>Стратегийн зорилт 2. Сум, суурин газрын болон малчдын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулна:</p>	<ul style="list-style-type: none"> ▪ төвлөрсөн системд холбогдоогүй сум, суурин газруудыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбохын зэрэгцээ сэргээгдэх эрчим хүч болон бусад эх үүсвэрүүдийг ашиглан байнгын цахилгаанаар хангах ▪ “Буман нарны гэрэл” хөтөлбөрийн хүрээнд бүх малчин айл өрхийг нар, салхины эрчим хүчний эх үүсвэртэй болгох ▪ нүүрсний ордуудад ойрхон байрлалтай сум, суурин газарт нүүрсний хийн түлшээр ажилладаг бага оврын цахилгаан станц барьж ажиллуулах 	<ul style="list-style-type: none"> • Увс аймгийн 19 сумыг төвлөрсөн системд холбож дууссан. Хөдөөгийн төвийн багууд Өмнөговь сумын Холбоо, Орлого, Тэс сумын Таван улиас, Хяргас сумын Хангай, Өндөрхангай сумын Жаргалант, сагил сумын Баянзүрх багууд, Хөх харгайн застав, Улаанхотгорын газар тариалангийн суурин зэрэг газруудыг холбох хөтөлбөр хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан хэрэгжих эсэх нь тодорхойгүй байна. • “Буман нарны гэрэл” хөтөлбөрийн хүрээнд аймгийн нийт 9328 малчин өрхийн 4100 өрх НЦҮ-гээр хангагдсан байна. Хөдөөгийн малчин өрхийн 45 хувь нь НЦҮ болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангагдаад байна. 	<p>100</p>
<p>5.3.4. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн бодлого Мэдээлэл, харилцааны технологийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 21 дүгээр зууны үндсэн хурдасгуур гэж үзнэ.</p>			
<p>Стратегийн зорилт 2. Мэдээлэл харилцааны технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт өргөн нэвтрүүлнэ.</p>	<p>Хөдөө орон нутагт утасгүй холбооны системийг эрчимтэй хөгжүүлж, 2015 он гэхэд үүрэн телефоны шинэ үеийн үйлчилгээг газрын суурь сүлжээг ашиглан хүн амын 60 хүртэл хувьд хүргэж, газар нутгийн 50 хүртэл хувийг зөвхөн газрын суурь сүлжээний тусламжтайгаар хамруулах</p>	<p>Холбооны мэдээллийн салбарт суурин утасны цэг 1933, үүрэн телефоны CDMA 2096, скайтель 10535, жимобайл 4784, юнитель 7471, мобиком 13785, бүгд 38671 хэрэглэгчтэй, интернет хэрэглэгч 73 байгууллага, 252 өрх хамрагдаж байна. Холбоо мэдээллийн хувьд аймгийн нийт хүн амын 50% хангагдсан байна.</p>	<p>100</p>
<p>5.3.5. Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалтыг эрчимжүүлнэ. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг дундаж хөгжилтэй орнуудын түвшинд хүргэнэ. “Хотууд” үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.</p>			
<p>Стратегийн зорилт 3. Хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулна. “Орон сууц” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ</p>	<p>▪ орон сууц барих санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, орон сууцны урт хугацаатай зээлийн анхдагч ба хоёрдогч зах зээлийн тогтолцоог бий болгон хөгжүүлэх, орон сууц барих сан байгуулж,</p>	<p>Орон сууц хөтөлбөрийн хувьд аймгийн Засаг даргын нөөц, орон нутгийн төсвийн хөрөнгөөр төрийн албан хаагчийн 24 айлын орон сууц барьж ашиглалтанд орууллаа. Төрийн албан хаагч 24 хүнд орон сууцыг 50% хямдруулан худалдсан нь Монгол Улсын</p>	<p>100</p>

	<p>орон сууцны гэрээт хадгаламжийн системийг нэвтрүүлэх</p> <ul style="list-style-type: none"> 2021 он гэхэд айл өрхийн дийлэнхи олонхийг орон сууцтай болгох 	<p>хэмжээнд хамгийн хямд орон сууцаар хангасан арга хэмжээ боллоо. Мөн Засгийн газрын бондын хөрөнгөөр төрийн албан хаагчийн 20 айлын орон сууц ашиглалтанд оруулж иргэдэд олгох арга хэмжээ авч байна.</p>	
--	--	---	--

6. Байгаль орчны бодлого
 Агаар мандал, газар, түүний хэвлийн баялаг, ой, ус, ан амьтан, ургамлын олон янз байдлыг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, цөлжилт, гангийн нөлөөг бууруулах, химийн хорт бодис, цацраг идэвхт хаягдлыг багасгах, хог хаягдлын менежментийг сайжруулах зэрэг хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэгдсэн эдийн засаг, нийгэм, экологийн цогц арга хэмжээ хэрэгжүүлэх бодлого баримтална.

<p>Стратегийн зорилт 1. Байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсооно.</p>	<p>Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлого хэрэгжүүлж, ажлын байр шинээр бий болгох</p>	<p>Зүүнговь сумын ЗДТГ өрхийн амьжиргааг дээшлүүлэх төслийн 1.6 сая төг-ийн санхүүжилтээр сумын төвийн хогны цэгийг дарж булаах ажлыг, Бөхмөрөн суманд хог менежмент төслийн хүрээнд БОХ сангаас 400.0, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1500.0 нийт 1900.0 мян.төг, Түргэн суманд 100тн хог хаягдал дарж зайлуулах ажлыг хийж нийт 1560.0мян.төг-ийн санхүүжилтээр, Малчин суманд – Хог “ төслийн хүрээнд сумын төв орчмын бүх хогийг дарж цэвэрлэн хогийн төлвөрсөн нэг цэгийг байгуулах ажлын хүрээнд нийт 3.2 сая төг-ийн санхүүжилтээр тус тус хийгээд байна.</p> <p>1. Бүх сумдын нийтийн хог хаягдлын цэгийг тохижуулж хог ачдаг морин тэрэг трактортой болсноос гадна тухайн сумын ИТХ-р хог хаягдлын үнэ тарифыг албан газар, аж ахуйн нэгж, айл өрх бүрээр нь оруулан хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлж ажиллаж байна. Сум бүр хавар намар аян зохион цэвэрлэгээний ажлуудыг тогтмол хийж байна. Жишээ нь: Гялгар уут цэцэг биш, Хоггүй орчинд амьдарцгаая, Цэвэр орчин, Чихрийн цаас хог Аймгийн төвийн нийтийн хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулах БОЯ-ны төсөлд хамрагдан 135 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлээд явж байна. Төслийн ажил дуусаагүй Төслийн</p>	<p>70</p>
---	---	--	------------------

		<p>хүрээнд хуванцар боловсруулах жижиг оврын үйлдвэрийг оруулж ирсэн цахилгааны шугам татах хөрөнгөгүйгээс ажиллаж эхлээгүй тоног төхөөрөмжийг байрлуулсан байгаа.</p> <p>2. Аймгийн төвийн гудамж талбай, албан газруудын үүдэнд нийт 60ш хогны савыг байрлуулсан нь гудамж талбайд хог хаягдал хаях асуудал багасаж, Аймгийн иргэдийн хурлын санхүүжилтээр 60 савыг хятад улсаас авч ирж байрлууллаа.</p>	
<p>Стратегийн зорилт 2. Газар, газрын хэвлийн баялагийг зохистой ашиглах нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ</p>	<p>Монгол үндэстний үеийн үед онцлон хайрлаж, онгон байдлаар нь хадгалан үлдээх газар нутгийн үндэсний өвийн санг буй болгож, хамгаалалтанд авах, тусгай хамгаалалттай газар нутгийн талаар баримтлах төрийн бодлого, менежментийг боловсронгуй болгох</p>	<p>Увс нуурын ай савын УТХГН - нь1997 онд НҮБ-ын Соёл, Шинжлэх ухаан, боловсролын байгууллагын “Хүн ба шим мандал” хөтөлбөрийн хүрээнд хамрагддаг “Дэлхийн Шим мандлын нөөц газарт” 2003 оны 8-р сард Дэлхийн байгалийн өвд ОУ-ын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай РАМСАР-ын конвенцид 1999 онд Айраг нуур, 2004 онд Увс, Ачит нуур туус тус хамрагдсан.</p>	<p>70</p>
	<p>Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн түүний удирдлагын тогтолцооны оновчтой бүтцийг бий болгож, орчин үеийн шаардлага хангасан хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх</p>	<p>Увс аймгийн хэмжээнд нийт 1390195 га талбай бүхий газар нутаг УТХ-нд авагдаж аймгийн газар нутгийн 19.97 хувь 440218.7 га газар нутгийг орон нутгийн хамгаалалтанд авснаар нийт аймгийн газар нутгийн 25 орчим хувийг хамгаалалтанд хамруулаад байна ТХГН-ийн сүлжээг үе шаттайгаар өргөтгөж байгаа. 2000 онд Хан-хөхий, Хяргас нуурын БЦГ,2006 онд Тэсийн голын байгалийн нөөц газар, 2008 онд Гоожуур, Баянзүрхийн ДЦГ-ыг өргөтгөн байгуулсан. 2010 онд Алтан хөхийг БНГ-ын ангилалаар улсын тусгай хамгаалалтанд хамруулсан.</p>	
<p>Стратегийн зорилт 3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах,</p>	<p>Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах харилцааг зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, ус</p>	<p>Увс аймгийн Сагил, Түргэн, Тариалан, Наранбулаг, Ховд, Хяргас, Малчин сумын нутагт нэр бүхий 8 булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг аймгийн Засаг</p>	<p>90</p>

<p>зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. “Ус” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ</p>	<p>хэмнэх усны нөөцийн менежмент, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах</p>	<p>даргын 149 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг сонгон шалгаруулалт хийж Ногоон алт сан төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, 2009 онд Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны санхүүжилтээр Бөхмөрөн, Ховд, Өлгий, Өмнөговь, Хяргас сумуудад 221 сая төгрөгийн өртөгтэй 15 инженерийн хийцтэй худаг шинээр гаргалаа.</p> <p>Усны мэргэжлийн байгууллага болох Ус-эрдэнэ ХХК нь 2009 онд 115,0 сая төгрөгийн ажил гүйцэтгэж төсвийн хөрөнгөөр 14, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 12 гүн өрмийн худаг гаргасан. ССТ-Од ХХК нь Сагил сумын Боршоон голын адагт 300 га талбайд 596 сая төгрөгийн өртөгтэй услалтын систем шинээр барьж мөн аймгийн Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний станцын 40га талбайд 176 сая төгрөгийн ажил гүйцэтгэж услалтын систем барьсан. Түргэн сумын нутагт хээр морьт гэдэг газарт 7,1 сая төгрөгийн өртөгтэй 10га талбай услах хүчин чадал бүхий хөв барьж ашиглалтанд оруулж Энержифлоу-констракш ХХК нь энэ онд улсын төсвийн хөрөнгөөр 8 гүн өрмийн худаг гаргасан.</p>	
	<p>Гадаргын усны тодорхой хэсгийг аж ахуйн эргэлтэнд оруулан арвижуулах замаар хүн ам, үйлдвэрлэлийн усан хангамжийг шийдвэрлэх</p>	<p>Монгол орны баруун захын Монгол Алтай, Сийлхэм, Хархираа, Түргэний уулс, Говь-алтай нуруудыг хамардаг Алтайн уулархаг их мужийн газар доорхи усны дундаж эрдэсжилт нь 640 мг/л, дундаж хатуулаг нь 4,8 мг-экв/л, натри, хлор ионууд зонхилсон, давсархаг, фторжсон устай. 2000 оны байдлаар улсын хэмжээнд 500 орчим сая шоо метр / бүрэн бус мэдээгээр / ус хэрэглэж байгаа, энэ нь 1990 оныхтой харьцуулахад 1,5 дахин буурсан гэсэн мэдээлэл байна.</p> <p>Хүн амын ундны усан хангамжинд нийтдээ 198 худаг ашиглагдаж</p>	

		байна. Унд ахуйн зориулалттай худгууд сумын Засаг даргын захирамжаар хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоож заримыг нь тэмдэгжүүлж байна	
<p>Стратегийн зорилт 4. Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцөлийг хангана.</p>	<p>Ойн санд сансрын мэдээ ашиглаж, зайнаас тандан судлах аргаар хайгуул, судалгаа хийж, тархалт, бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоон ойн зураглал, ойн тогтвортой менежментийн хөтөлбөр боловсруулж, газар зүйн мэдээллийн тогтолцоонд суурилсан ойн мэдээллийн сан байгуулах</p>	<p>Увс аймагт ойн нөөцийг зохистой ашиглах, таримал ойн хэмжээг нэмэгдүүлэх, хот суурин газарт ногоон байгууламжийг өргөжүүлэх зорилгоор “Ногоон гом” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулан хэрэгжүүлж байгаагаас гадна 2000 онд Ханхөхийн нурууны ой, 2007 онд Алтайн нурууны салбар уулс Хархираа, Түргэний уулсын ой, 2008 онд Тэс, Торхилогийн голын сав газрын бургасан ойн зохион байгуулалтыг тус тус хийж ойн мэдээллийн бүрэн хэмжээний сантай болсон.</p> <p>Ой бүхий бүх сумдын Ойн менежмент төлөвлөгөөг загварын дагуу 5 жилээр боловсруулж Ойн газрын даргаар батлуулж, аймгийн ойн менежмент төлөвлөгөөг боловсруулж хянуулан батлуулахаар БОАЖЯ-нд хүргүүлэн батлуулж аймгийн хэмжээнд хэрэгжүүлж эхлээд байна.</p>	70
	<p>Стратегийн дунд хугацааны зорилтын хүрээнд уур амьсгалыг зөөлрүүлж, цөлжилт, хөрсний эвдрэл, түйрэн, элсний нүүдэлтэй тэмцэх зорилгоор ойг нөхөн сэргээх, говь, хээрийн бүсэд мод тариалж ногоон зурвас байгуулах</p>	<p>Ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэх мэргэжлийн байгууллагуудыг сонгон шалгаруулах, ойжуулалтын ажилд хяналт тавих, хүлээн авах аймгийн үнэлгээний хороог Засаг даргын 2009 оны 38 тоот захирамжаар байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулж, ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний 2009 оны улсын даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хүлээн авах, “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ойн зурвас, төгөл байгуулах гэрээг Ойн газартай байгуулан ажиллаж байна.</p>	

		<p>Гэрээний дагуу аймгийн хэмжээнд 223 га талбайд ойжуулалт, 15 га–д Ногоон хэрмийн туслах зурвас төгөл байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагууд гүйцэтгэлээ. Ойжуулалтын ажлыг Зүүнговь сумын Харбураа, Улаангом сумын Цагаан бураа, Тэрэм хад, Өндөрхангай сумын Могойн бэлчир, Сагил сумын Далт зэрэг газруудад хийсэн ба Ногоон хэрмийн туслах зурвасыг Наранбулаг, Завхан, Улаангом зэрэг сумдад хийж гүйцэтгэлээ. Говийн бүсийн сумдын усны хангамжийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвөөс санхүүжүүлэн Зүүнговь сумын төвд 3 га газрыг хашаажуулан худаг гаргаж, шар хуайсны, улиас бургасны 1000 гаруй суулгац, Өмнөговь сумын төвд 10 га газарт 1000 орчим суулгац тариулсан нь намрын тооллогоор 75-аас дээш хувьтай, хангалттай үнэлгээтэй ургаж байна. Тэс сумын нутаг Нарийний адагт цөлжилт, элсний нүүлтээс сэргийлэх, хөрсийг бэхжүүлэх зорилгоор 500 кг олон наст, согооворын үр цацууллаа. Ойн үрийн талбай тусгаарлах ажлыг Геозкологийн хүрээлэнгийн ойн салбартай хамтран хийхээр гэрээ байгуулсны дагуу Геозкологийн хүрээлэнгийн ойн салбарын эрдэм шинжилгээний 2 ажилтан ирж, Баруунтуруун сумын Хар цагаан усны эх Өвөржингийн амны ойд ойн байнгын үрийн талбайг тусгаарлах ажлыг 50 га-д хийж гүйцэтгэлээ.</p>	
	<p>Ой хамгаалах ажилд дэвшилтэт менежментийн арга хэлбэрийг нэвтрүүлж, ойн сангийн 20 хүртэлх хувийг нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр</p>	<p>Аймгийн хэмжээгээр байгаль хамгаалах иргэдийн 24 нөхөрлөл байгуулагдсанаас 7 нь ойн санг хамгаалах чиглэлийн, үлдсэн нь байгалийн баялаг, ан амьтныг хамгаалах, зохистой ашиглах чиглэлээр үйл ажиллагаагаа</p>	<p>90</p>

	<p>эзэмшүүлэн ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх</p>	<p>явуулж байна. 2009 онд шинээр Цагаанхайрхан суманд 2, Өндөрхангай суманд 1 ойн нөхөрлөл байгуулагдахаар баримт бичгээ бүрдүүлэн одоо сумын ИТХ-ын шийдвэрийг хүлээгээд байж байна. Байгуулагдсан нөхөрлөлүүдийн гишүүдийг сумын буюу аймгийн түвшинд туршлагыг сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулж чуулга уулзалтыг Баянөлгий, Ховд аймгийн төвүүдэд, Бөхмөрөн, Ховд, Улаангом сумын төв, Хархираа амралтын газруудад ДБХС-ын МдХГ-ын Увс аймгийн нэгж, АСБТЗАИОХТөслийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулсан нь үр дүнтэй арга хэмжээ болсон. Энэхүү ажлын хүрээнд 6 нөхөрлөлийн 7 гишүүнийг 6 идэвхтэн байгаль хамгаалагч нарын хамт амьтан, ургамлын судалгаа шинжилгээний анхан шатны арга зүй эзэмшиж, хээрийн судалгааны ажлыг нөхөрлөл тус бүрийн хариуцан хамгаалах газар нутагт хамтран хийсэн юм.</p> <p>“Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл үүсэхэд талуудын оролцоо” уулзалт зохион байгуулав.</p> <p>“Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежмент”-ийг хэрэгжүүлэх төслийн бүс нутаг болох Бөхмөрөн, Сагил сумуудын удирдлага, байгаль орчны ажилчид, нөхөрлөлийн ахлагч нарын хоорондын ойлголцол, хамтын ажиллагааг сайжруулах мөн талууд гэрээ байгуулж, байгаль хамгаалах малчдын нөхөрлөлд газар эзэмших гэрчилгээ олгуулах зэрэг ажлууд шат дараатай хийгдэж байна.</p> <p>Байгаль хамгаалах нөхөрлөлийн өнгөрсөн хугацааны ололт амжилт, алдаа дутагдал, цаашдын чиг хандалгыг тодорхойлох, малчид болон нөхөрлөл бэлчээрийн зүй зохистой ашиглалтыг хэрхэн буй</p>	
--	--	--	--

		<p>болгох улмаар зэрлэг амьтдын амьдрах орчныг хамгаалах талаар санал солилцож нэгдсэн ойлголтонд хүрэх зорилго бүхий “Тогтвортой хөгжлийн төлөө хамтдаа” сэдэвт байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн туршлага солилцох өдөрлөг, зөвлөлгөөнд нөхөрлөлүүд оролцсон.</p> <p>Нөхөрлөлийн гишүүдийн байгаль хамгаалалын чиглэлийн мэдээллээр байнга хангаж, холбогдох гарын авлага, ном материалыг хүргүүлж, жижиг төсөл хөтөлбөрүүдэд хамруулах, тэдэнд заавар зөвлөгөө өгөн дэмжин ажиглаж байгаа ба улсын төсвийн санхүүжилтээр Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан сумын ойн санг эзэмшин хамгаалж байгаа Давшилт Увс, Хорин булаг, Баянханхөхий, Буган толгой, Ханхөхийн цуурай зэрэг нөхөрлөлийн ойн санд ой зохион байгуулалтын ажлыг хийлгэж, нөөцийг тогтоолгосон ба материал боловсруулалтын шатанд байна.</p>	
<p>Стратегийн зорилт 5. Амьтан, ургамлын аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлаж, тэдгээрийг байгалийн жамаар нөхөн сэргэх, тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	<p>Нэн ховор, ховор амьтны популяцийн тогтвортой байдал, хэвийн өсөлтийг хангахтай холбогдсон зохион байгуулалтыг шинэчлэн, тэдгээрийг хамгаалах эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлж, зориудын аргаар үржүүлэх, тэдгээрийн удмын санг бий болгож, генийн санг хамгаалахад биотехнологийн ололтыг ашиглаж, биологийн найдвартай нөөцтэй болох арга замыг судлан боловсруулах</p>	<p>Ховор ховордсон зүйлийг хамгаалахын зэрэгцээ нийт экосистемийг төлөөлж чадахуйц тусгай хамгаалалттай газар нутгийг иж бүрэн бүрдүүлэх, тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа шинжилгээний ажил явуулах ажлын хүрээнд Шинжлэх ухаан академийн Биологийн хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн 2009 оны 3 сарын 14-ны өдрийн хурлаар баталсан Уулын туруутны популяцийн анхан шатны мэдээ цуглуулах, Цоохор ирвэсний популяцийн анхан шатны мэдээ цуглуулах, Монгол тарваганы анхан шатны мэдээ цуглуулах, Ойн туруутны анхан шатны мэдээ цуглуулах, Шувуу судлах хээрийн судалгааны анхан шатны арга зүйг УНАСУТХГ-ын 4 дархан цаазат газар, 2 байгалийн цогцолборт</p>	<p>90</p>

		<p>газрын нийт 17 байгаль хамгаалагчид эзэмшүүлж, уулын тууртан, ойн тууртан, цоохор ирвэс, шувуу, тарваганы судалгааны дээж талбай сонгон, судалгааны цэг, талбайг урьдчилан бэлтгэсэн 1: 100 000 масштабтай газрын зурган дээр тэмдэглэж, тухайн мониторинг судалгаа явуулах хугацааг байгаль хамгаалагч нартай тохиролцож, мэдээллийг бэлтгэсэн хүснэгтэн дээр тэмдэглэж Хамгаалалтын захиргаанд ирүүлж нэгтгэх ажил хийгдэж байна.</p>	
	<p>Ан амьтны нөөц, байршил нутгийг тогтоон хамгаалахад зориулагдсан дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхүйц олон улсын байгууллага, хандивлагч орон, хувь хүний дэмжлэгтэй урт, богино хугацааны төслийг үр ашигтай хэрэгжүүлэхийг дэмжих</p>	<p>Биологийн төрөл зүйл ба түүнд учирч байгаа хор хөнөөлийн талаар мэдлэгийг дээшлүүлэхтэй холбогдсон судалгааны ажил хийх ажлын хүрээнд Аргаль хонийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг судалгаа шинжилгээний үндсэн дээр батлуулан аргаль хонийг хамгаалах өсгөн үржүүлэх тал дээр олон арга хэмжээг авч ажиллаж байна. ШУА-ын Биологийн хүрээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар хамтран ОХУ-тай хиллэдэг Бөхмөрөн, Сагил сумдын хил орчмын аргаль хонины тархалт шилжилт хөдөлгөөн, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, хамгаалалтыг сайжруулах зорилгоор зайнаас тандан судлах зэрэг тэргүүний технологийг ашиглан цаашдын ажиглалт, хяналт, шинжилгээний ажлын үр өгөөжийг сайжруулах замаар Бөхмөрөн сумын Мандахын Аараг хэмээх газарт судалгааны цэг байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2009 оны 4-р сарын 16-наас 21-ний өдрүүдэд аргалийн 3 хурга түр барьж радио дохиолол зүүлээ. Одоо 2 хурга нь дохиололтой мэдээллийг цуглуулж байна. Тус хэсгийн байгаль хамгаалагч мэдээлэл цуглуулан шилжилт</p>	<p>90</p>

		<p>хөдөлгөөнд нь хяналт мониторинг хийн ажиллаж байна. Монгол улсын хил орчмын аргаль хонины 25% нь Увс аймгийн Бөхмөрөн, Сагил сумдын нутагт байршиж байгаа учир 2 сумдын аргаль хонины байршил нутгийг “Гулзат” нэртэйгээр орон нутгийн тусгай хамгаалалтанд авч шийдвэрийг гаргуулсан байна</p>	
	<p>Ховор, нэн ховор ургамлын тархац нутаг, нөөцийн судалгаа хийх, удмын санг хамгаалах, генийн сан байгуулах, бүртгэл, мэдээлэл-хяналт шинжилгээний тогтолцоо бүрдүүлэх, ашиглалтыг зохицуулан төлөвлөх, сэргээн ургуулах, тарималжуулах ажил зохион байгуулах</p>	<p>Зарим сумдад зэрлэг чацарганы болон эмийн ургамлын судалгаа хийж нөөц тогтоох, эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах талаар: Ховд, Бөхмөрөн, Тэс голын дагуу ургадаг чацарганы судалгааг хийгдэж тайлан боловсруулагдан гарсан байна.</p> <p>Эмчилгээ хүнсний зориулалтаар ашиглагддаг эмийн ургамлыг тарималжуулах, ашиглах ажлыг дэмжих ажлын хүрээнд Улаангом сумын хэмжээнд чацаргана тариалсан иргэн, аж ахуйн нэгжүүдийг хамруулсан судалгааны ажил хийгдэж судалгаагаар жимсний зориулалттай эргэлтийн нийт талбай 1055.0 га үүнээс чацаргана 1013.4 га, үхрийн нүд 41.6 га тариалалт хийсэн талбай 266.9 га, чацаргана 231.3 га, үхрийн нүд 35.6 га талбайтай байна.</p>	
<p>Стратегийн зорилт 6. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд дасан зохицож, сөрөг үр дагаврыг бууруулах чадавхийг бүрдүүлж хэрэгжүүлнэ.</p>	<p>Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн төлөв байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бодлого хэрэгжүүлэх</p>	<p>Увс аймгийн нутаг нь Монгол улсын баруун хойт хязгаарт Төв азийн усны хагалбар, Алтай, Хангайн уулсын уулзварт дэлхийн байгалийн бүс бүслүүрийн бүхий л шинж төрхийг өөртөө агуулсан Увс нуурын их ай сав хэмээх Их нууруудын хотгорт оршдог газарзүйн онцлогоос үүдэн өөрийн гэсэн давтагдашгүй уур амьсгалыг бүрдүүлж байдаг. Аймгийн нутагт олон жилийн дундаж агаарын температур 0.0⁰-аас -5.2⁰С хүртэл хэлбэлздэг.</p> <p>Олон жилийн дундаж агаарын температурын хуваарилалтаас үзэхэд аймгийн нутгийн өмнөөс хойшоо хүйтэрсэн байх ба мөнх</p>	<p>90</p>

		<p>цас, цэвдэгтэй өндөр уулс, Ханхөхийн ар талын сумдын нутгаар -4.0-5.2⁰С, Өмнө ба баруун өмнө талын сумуудаар 0.0-2.0⁰С, бусад нутгаар -2.0-4.0⁰С хүйтэн байдаг.</p> <p>Цаг уурын ажиглалт судалгааны үр дүнгээс харахад дэлхийн уур амьсгалын дулааралтай уялдан манай аймгийн нутагт сүүлийн жилүүдэд дулааны улиралд үүл багатай цэлмэг цаг агаар зонхилох нь газрын гадарга хэт халах, агаар хуурайших, үүлсэх боломж багассанаас тунадасны үргэлжлэх хугацаа богиносох, услаг ихтэй аадар тунадас орох, борооны өмнө хүчтэй салхи үүсэх зэрэг нь орон нутгийн уур амьсгалд сөрөг нөлөөлж байна.</p> <p>Газар зүйн байршил, уур амьсгалын эрс тэс, хахир ширүүн уур амьсгалтай манай аймгийн хувьд өвлийн улиралд тогтсон цасан бүрхүүл ба 4-5 сард унасан тундасны нөлөөгөөр хавар эрт цухуйсан ургамал нь 6 сарын дунд ба сүүлийн арав хоног, 7 сарын эхний арав хоногийн их халалтаас үет ургамлын ихэнх нь боловсорч үр жимсээ өгөх хугацаанаас өмнө хатаж гандан зуншлагын байдал муудаж улмаар өвөлжилт хүндрэх явдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна.</p> <p>Сүүлийн жилүүдэд хур бороо бага, хэт хуурай_ салхи шуурга ихтэй байснаас бэлчээрийн 60 орчим хувь нь гантай ба гандуу, 40 орчим хувь нь зуншлага хэвийн байсны зэрэгцээ бэлчээрийн үржил шим, ургамлын төрөл зүйл багасах, даац, багтаамжийн хүрэлцээ муудах, хортон шавьжинд идэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл ихсэх хандлагатай байна.</p>	
	<p>Байгаль, цаг уурын нөлөөллийн улмаас хуурайшин гандаж, доройтолд өртсөн болон өртөх магадлал бүхий</p>	<p>Цөлжилттэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд цөлжиж байгаа газар нутгийн судалгааг Баруунтуруун сумын Алтан элсний хаяа дагуух газрууд, тариалангийн</p>	<p>90</p>

	<p>газар нутгийн төлөв байдлыг тодорхойлж, тухайн бүс нутгийн онцлогт дасан зохицох чадавхийг бэхжүүлэх</p>	<p>атаржсан талбайнууд, Туруун голын адаг орчмын газрууд нийт талбайн 45,3 га, Завхан сумын Ар модны район, Завхан голын дагуу нийт талбайн 250 га, Зүүнговь сумын төвийн эргэн тойрон, Шар нурган, төвөөс 16км-т сайгийн элсний нүүлт ний талбай 1500 га, Өмнөговь сумын Бор хаг, Бэлчир, Намирын баруун хөдөө, Намирын зүүн хөдөө, Бага шар бүрд, Рашаантын хөдөө, Сөрт, Адгийн худаг, Шар булаг, ний талбай 91,5 мян/га, Өлгий сумын Бөхөн шар уулнаас, Өгөөмөрийн хар уул хүртэлх газар нутаг бүхэлдээ нийт талбай 10521,8 га Наранбулаг сумын Дөш сорхог, Улааны бөгц, сумын төв орчмын газрууд нийт талбайн 5000 га Ховд сумын Хар улааны бэл, Онцын хотгор нийт талбайн 750 га газрууд цөлжилтэнд нэрвэгдсэн судалгаагаар тогтоож мөн аймгийн хэмжээнд цөлжиж байгаа газруудын судалгааг нэгтгэн гаргаж цаашид авах арга хэмжээний чиглэлийг боловсруулах ажлыг хийж эхлээд байна,</p> <p>Цөлжилтэд нэрвэгдсэн газруудын судалгааг бүх сумуудаас тусгай хүснэгтийн дагуу авч, нэгтгэн, мэдээллийн санг баяжууллаа. Судалгаагаар 240.0 мян га цөлжилтэд нэрвэгдсэнээс 2006 онд 22106.5 га-д үлийн цагаан оготно, 98312.6 га-д царцааны нүүдэл идэвхжиж талхлагдсан байна. Царцааны тэмцлийн ажлыг тархалт бүхий Зүүнхангай, Баруунтуруун, Наранбулаг, Малчин,Түргэн зэрэг сумдын нутагт хийж байна.</p> <p>Говийн бүсийн сумдын усны хангамжийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвөөс санхүүжүүлэн Зүүнговь сумын төвд 3 га газрыг хашаажуулан худаг гаргаж, шар хуайсны, улиас</p>
--	---	--

		<p>бургасны 1000 гаруй суулгац, Өмнөговь сумын төвд 10 га газарт 1000 орчим суулгац тариулсан нь намрын тооллогоор 75-аас дээш хувьтай, хангалттай үнэлгээтэй ургаж байна.</p> <p>Тэс сумын нутаг Нарийны адагт цөлжилт, элсний нүүлтээс сэргийлэх, хөрсийг бэхжүүлэх зорилгоор 500 кг олон наст, согооворын үр цацууллаа.</p> <p>Цөлжилтэй тэмцэх хөтөлбөрийн ажлын төлөвлөгөөний дагуу “Мод тарьж ургуулсан иргэн аж ахуйн нэгж байгууллагад урамшуулал олгох” журам боловсруулж аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Засаг даргын 356 тоот захирамжаар батлуулан сумдад зааварчлага өгч хүргүүлсэн билээ. Энэ ажлын хүрээнд Наранбулаг, Өмнөговь, Улаангом зэрэг сумдын 30 гаруй айл өрх, 5 аж ахуйн нэгж 3200 орчим мод тарьж гэрээ байгуулан, эдгээрт шаардагдах урамшуулын санхүүжилтыг нэхэмжлээд байна.</p>	
7.1 Эрх зүйн шинэтгэл			
<p>Стратегийн зорилт 1. Төрийн институцүүдийг чадавхжуулж, төрийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.</p>	<p>Төрийн захиргааны байгууллагаас гаргах эрх зүйн актын боловсруулалтыг шинжилгээ судалгааны үндэстэй, системтэй болгох</p>	<p>Аймгийн Засаг даргын 2009 оны 245 тоот захирамжаар аймгийн Засаг даргын захирамж боловсруулах батлах журмыг батлан хэрэгжүүлж ажиллаж байна. Энэхүү журмын зорилго нь аймгийн Засаг даргын захирамжийн эрхзүйн үндэслэлийг хангуулах, эрхзүйн зөрчилгүй захирамж гаргах юм. Журмаар захирамжийг боловсруулах, хянах, зөвшөөрөл олгох, ёсчлох бүхий л ажиллагааг журмалж, тавигдах шаардлага, хариуцах албан тушаалтаныг тодорхойлсон. Засаг дарга хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд сумын Засаг даргы нарын шийдвэрт хяналт тавьж, эрхзүйн актыг боловсронгуй болгох талаар зөвлөмж өгч ажиллаж байна. Мөн түүнчлэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний</p>	100

		<p>агентлагийн дарга нарын иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндсөн, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт хяналт тавьж ажиллаж байна.</p>	
	<p>Хууль тогтоомжийг чанд баримталж хэрэгжүүлдэг тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар Засгийн газрын тогтоол, албан даалгавар, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу орон нутагт зохих шийдвэр гарган ажиллаж, төрийн байгууллага, албан хаагчдын ажлын үр дүнгийн гэрээнд тусган хариуцлага тооцож ажиллаж байна. Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн мэдээг улирал бүрээр тооцон гаргаж ЗГХЭГ-т хүргүүлдэг.</p>	
<p>Стратегийн зорилт 2. Хүний эрхийг баталгаатай хангана.</p>	<p>Хүний эрх, эрх чөлөөг хангахад шууд үйлчилдэг тогтолцоог төрийн эрх мэдлийн хуваарилалтыг тэнцвэржүүлэн төгөлдөржүүлэх замаар боловсронгуй болгоно</p>	<p>Аймаг, орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд хууль хяналтын байгууллагуудтай харилцан хамтарч ажилладаг. Аймаг сумын ИТХ-ын дарга нар ГХУСАЗЗ-ийн салбар зөвлөлийг удирдаж, хууль хяналтын байгууллагуудын дарга нарын төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах талаар төлөвлөгөө гаргаж хамтарч ажилладаг. Хууль хяналтын байгууллагууд сар бүрийн өөрийн үйл ажиллагааны талаар танилцуулга, мэдээллийг аймгийн ИТХ, Засаг дарга ирүүлдэг ба жилд 1 удаа аймгийн эрүүгийн нөхцөл байдал, нийгмийн хэв журмыг сахиулах ажлын талаар Цагдаагийн газрын даргын сонсголыг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж, үүрэг чиглэл өгч ажиллаж байгаа болно. Түүнчлэн дээрх байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулахад зориулж зохих дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал: Цагдаагийн газарт хөдөлгөөнт эргүүлийн машин авахад зориулж 4 сая төгрөг, Тагнуулын газарын дотоод тохижилт, тоног төхөөрөмж авахад зориулж 3.0 сая төгрөг гэх мэт.</p>	<p>100</p>

7.3. Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийн бодлого

Төрийн албыг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүргэх чадвартай болгон шинэтгэх бодлого хэрэгжүүлнэ.

<p>Стратегийн зорилт 1. Төрийн албаны стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг хөгжүүлнэ.</p>	<p>Төрийн албаны, ялангуяа ерөнхий менежерийн стратегийн төлөвлөлтийн чадамжийг бэхжүүлэх</p>	<p>Төрийн албаны, ялангуяа ерөнхий менежерийн стратегийн төлөвлөлтийн чадамжийг бэхжүүлэх зорилгоор төсвийн ерөнхий менежерийн манлайлалыг хөгжүүлэх Манлайлал-Менежментийн сургалтзохион байгуулан явуулж байна. 2009 оны байдлаар төсвийн ерөнхий менежер 124 хүнийг Манлайлал-Менежментийн сургалтад хамруулж тэдний стратегийн төлөвлөлтийн чадамжийг сайжрууллаа. Цаашдаа төсвийн ерөнхий менежерийн Манлайлал-Менежментийн сургалтыг жил бүр тогтмол зохион байгуулан явуулахаар төлөвлөөд байна.</p>	<p>100</p>
	<p>Төрийн албаны гүйцэтгэлд үндэслэсэн удирдах чадавхийг бэхжүүлэх</p>	<p>Төрийн албаны гүйцэтгэлд чиглэсэн удирдах чадавхийг бэхжүүлэх зорилгоор төсвийн ерөнхий менежерүүдэд гүйцэтгэлийн менежмент, гүйцэтгэлийн үнэлгээ хийх чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулан явуулж байна.</p>	
<p>Стратегийн зорилт 2. Төрийн албаны бодлого, дүн шинжилгээний болон төрийн албан хаагчийн манлайллын чадамжийг шинэ түвшинд хүргэнэ.</p>	<p>Төрийн албаны удирдах албан тушаалтан, ялангуяа ерөнхий менежерийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах</p>	<p>Төрийн албаны удирдах албан тушаалтан, ялангуяа ерөнхий менежерийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулалт явуулж томилгоо хийж байна. Төсвийн ерөнхий менежерийн ажлын байрсул чөлөөтэй болсон тохиолдолд төрийн албан зөвлөлийн 2003 оны 13 дугаар тогтоолоор батласан “Төсвийн байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх дарга, захирал эрхлэгчийг сонгон шалгаруулах журам”-ыг баримтлан сонгон шалгаруулалт явуулахаас нэг сарын өмнө зарлал мэдээлэл гаргаж сум, байгууллагуудад хүргүүлэн зохион байгуулалтын ажил хийж байна. 2009 онд Хяргас, Наранбулаг</p>	<p>100</p>

		сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Сагил, Цагаанхайрхан, Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн ЗДТГ-ын нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын ажлын байранд сонгон шалгаруулалт зохион байгуулан явуулж дээрх ажлын байранд томилгоо хийгдлээ.	
Стратегийн зорилт 3. Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийг хангана.	Дотоод шийдвэр нь ил тод, ажлын гүйцэтгэлд чиглэсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх	Дотоод шийдвэр нь ил тод, ажлын гүйцэтгэлд чиглэсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэхийн тулд долоо хоног бүрийн Баасан гаригт ЗДТГ-ын аппаратын шуурхай цуглаан, мөн Даваа гариг бүрт төсвийн болон аж ахуйн байгууллагын удирдлагуудын нэгдсэн цуглаан тус тус зохион байгуулж төр засаг, аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрүүд танилцуулах, тэдний санал хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулах ажил хэвшил болоод байна. Зарим нийтийг хамарсан шийдвэрүүдийг орон нутгийн радио, телевиз, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажил тогтмол хийгдэж байна. Сум, агентлагийн 2009 оны ажил дүгнэхдээ үнэлгээ бодитой байх, үнэнд ойртуулах зорилгоор удирдлагаас өгч байгаа үнэлгээнээс гадна хэрэглэгчийн болон хамт олны үнэлгээг харгалзан дүгнэдэг зарчимд шилжээд байна.	100
	Төрийн албан хаагч бүрт хүний нөөцийн удирдлагын ур чадварыг эзэмшүүлэх	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын ур чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулан явуулж байна. Одоогийн байдлаар төсвийн ерөнхий менежер 124 хүнийг энэхүү сургалтад хамруулаад байна.	
Стратегийн зорилт 4. Хүний нөөцийн удирдлагын	Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн үндэсний хэмжээний шинэ тогтолцоог	Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг HRMS программаар нэгтгэж цахим хэлбэрээр бүрдүүлээд байна.Одоо	100

мэдээллийн болон цалин хөлс, хангамжийн тогтолцоог төгөлдөржүүлнэ.	бүрдүүлэх	мэдээллийн цахим санд төрийн албан хаагч 4043 хүний мэдээлэл бүрэн хэмжээнээр хадаглагдаж байна. Цаашдаа Засагийн газар болон Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн мэдээллийн сантай онлайн хэлбэрээр холбогдохоор төлөвлөж байна.	
	Төрийн албаны цалин хөлсний тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн харилцааны нөхцөлд тохируулах, ил тод болгох, гүйцэтгэл, урамшууллын оновчтой механизмтай холбох замаар боловсронгуй болгох.	Төрийн албаны цалин хөлс, нэмэгдэлтэй холбогдох асуудлыг Засгийн газрын тухайн үед мөрдөгдө байгаа тогтоол шийдвэрийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна. Төсвийн байгууллага бүр өөрсдийн дотоод журам болон холбогдох бусад шийдвэрүүдийг үндэслэн төсөв хөрөнгийн бололцоонд тулгуурлан урамшууллын механизмийг зохих хэмжээгээр хэрэгжүүлэн ажиллаж байна.	
Стратегийн зорилт 6. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийг эдийн засгийн чадамж, хүн амын нөөцөд тулгуурлан томсгоно:	Баг, хороог төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны хамгийн анхан шатны нэгжийнх нь хувьд бэхжүүлэх	Багуудыг жил бүрийн нийгэм эдийн засаг хөгжүүлэх зорилтод тусган ээлж дараатай контортой болгох багийн Засаг дарга хүн эмнэлгийг унаажуулах ажлыг зохион байгуулж байна.	100
	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг нутаг дэвсгэрийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх чадвартай болгон хөгжүүлэх.	Сумдын стратеги хөгжлийн хөтөлбөр боловсруулан тэргүүлэх чиглэл үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин хөгжүүлэх ажлыг сумдын ИТХ дээр батлан хэрэгжүүлж эхлээд байна.	
<p>7.5. Гадаад бодлого Гадаад бодлогыг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх, үр ашигтай түншлэлийг бий болгоход чиглүүлнэ. Хоёр хөрш болон дэлхийн бусад улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт өөрийн байр сууриа бэхжүүлэн, бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн ашиг сонирхлын талаасаа харилцан шүтэлцээ бүхий хамтын ажиллагааны сүлжээ бүрдүүлэх, өөрийн иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хилийн чанадад хамгаалах замаар бүрэн эрхт улсынхаа тусгаар тогтнол, аюулгүй байдлыг найдвартай хангах нөхцөлийг бүрдүүлнэ.</p>			
Стратегийн зорилт 1. Энхийг эрхэмлэсэн, идэвхтэй гадаад улс төрийн бодлогыг	Энхийг эрхэмлэж, аливаа улс гүрэнтэй сөргөлдөхгүй байх, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулах	ОХУ-ын Хакасс, Тува, Алтай улсуудтай хамтран ажиллах гэрээтэй. Хамтран ажиллах гэрээний хүрээнд оюутан сургах, урлаг спортын нөхөрсөг уулзалт тэмцээн зохион байгуулах, бараа	100

хэрэгжүүлнэ:		бүтээгдэхүүн авах ажлыг хийж байна.
	Монгол Улсаас Энэтхэг, БНСУ, АСЕАН-ы орнуудтай тогтоосон харилцааг улам өргөтгөж, эдгээр оронтой хөрөнгө оруулалт, соёл, хүмүүнлэгийн салбарт тогтоосон түншлэлийн хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэх	Энэтхэгийн Ладок мужтай шууд харилцаа тогтоох санал хүргүүлсэн. Гэрээний хүрээнд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, үйлдвэрлэлийн шинэ техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэх чиглэлийг түлхүү анхаарах талаар тусгасан санал хүргүүлсэн. БНСУ-ын Шинэ тосгон хөдөлгөөнтэй нягт хамтарч ажилладаг.
100		13
90		38
70		6
ДУНДАЧ ХУВЬ		90.1

УВС АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ЦОГТ-ОЧИР